



ИНД – 139

ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАГЦ ДҮРЭМ

**Аэродром – Гэрчилгээжүүлэлт, үйл ажиллагаа
болон ашиглалт**

Иргэний нисэхийн ерөнхий газар

Дүрмийн тайлбар

ИНД - 139 нь:

- Аэродромын гэрчилгээжүүлэлт болонүйл ажиллагаа ;
- Аэродромаюулгүй байдлын арга хэмжээ;
- Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид аэродром ашиглах; болон
- Холбоо, мэдээллийн UNICOM ба AWIB үйлчилгээнүүдийн хангалтын талаар ИНЕГ-аас тавигдах шаардлагуудыг тогтоосон болно.

ИНД-139 нь байгууллагыг гэрчилгээжүүлэх үйл ажиллагаанд холбоотой дүрмийн заалтуудын стандарт загварыг хэрэглэн боловсруулагдсан. Уг загварт аэродромын гэрчилгээжүүлэлтийн, үйл ажиллагааны, аюулгүй ажиллагааны аудитын тусгай шаардлагуудыг тайлбарласан. Мөн аэродромын гэрчилгээ эзэмшигчид аюулгүй байдлын талаар дагаж мөрдөх дэлгэрэнгүй шаардлагыг тусгасан болно.

Энэ дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Сайдын баталсан ИНД-139-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ.Хүчин төгөлдөр ИНД-139, түүний өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг дүрмийн зохицуулалтад шилжих тухай Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/ -ын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг Шинэ Зеландын Иргэний нисэхийн дүрэмд уялдуулан гаргасан болно.

ИНД-139 нь анх 2016 оны 3 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд дараах өөрчлөлтийг багтаасан:

Өөрчлөлтийн дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо
Өөрчлөлт 1	2002 оны 9-р сарын 17
Amendment 2	2006 оны 8-р сарын 03
Amendment 3	2010 оны 3-р сарын 22
Amendment 5	2016 оны ... сарын

ИНД-139-ийн Өөрчлөлт 5-ыг Шинэ Зеландын Part 139-ийн 2015 оны 9-р сарын 24-ний өдрийн Өөрчлөлт 11-д үндэслэн боловсруулсан болно.

Тэмдэглэл: ИНД-139-ийг англи болон монгол хэл дээр боловсруулсан ба эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбар нь давамгайлна.

А Бүлэг– Ерөнхий зүйл

139.1 Зорилго

Энэ бүлэгт дараахүйл ажиллагааны журмыг тогтооно:

- (1) аэродромын гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагааы журмууд;
- (2) гэрчилгээжсэн аэродромаюулгүй байдлын дүрэм, журмууд;
- (3) [Хүчингүй];
- (4) UNICOM болон AWIB үйлчилгээний журмууд.

139.3 Тодорхойлолт

Энэ хэсэгт

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч гэж –

- (1) аэродромыг ажиллуулагч; эсхүл
- (2) хэрэв(1)-д заасан ажиллуулагч тодорхой бус бол, тухайн аэродромын удирдлагыг хариуцагч, эсхүл
- (3) хэрэв(1) болон (2)–т заасанажиллуулагч тодорхой бус бол, аэродромын газрыг эзэмшигч; эсхүл
- (4) хэрэв(1), (2) болон(3)–т заасан ажиллуулагч тодорхой бус бол,уг аэродромын газрын бүртгэгдсэн өмчлөгчийг;

Газрын бүртгэгдсэн өмчлөгч гэж Монгол Улсын Газрын тухай хуулийн 5-р зүйлдтодорхойлсон газрын бүртгэгдсэн өмчлөгчийг тус тус ойлгоно.

139.5 Аэродромын гэрчилгээ эзэмшигчид тавигдах шаардлага

(аа) Энэ дүрэм дор дурдсан аэродромуудад хамаарна:

- (1) агаарын тээврийн тогтмол үйл ажиллагаа явуулах бүх төрлийн агаарын хөлөгт үйлчлэх аэродром нь, хэрэв-
 - (i) тухайн агаарын хөлгийн хөөрөх цэг Монгол Улсын гадна боловч Монгол Улсад буух бол, эсхүл
 - (ii) тухайнагаарын хөлгийн буух цэг Монгол улсын гадна орших боловч, хөөрөх цэг нь Монгол Улсад бол
- (2) Зорчигч тээвэрлэх агаарын тээврийн тогтмол үйл ажиллагаа явуулах, 30 – аас дээш зорчигчийн суудалтай үйлдвэрээс гэрчилгээжсэн онгоцонд үйлчлэх аэродромууд.

- (a) Аливаа этгээд Иргэний нисэхийн хууль болон энэ дүрмийн шаардлагыг хангажДаргаас аэродромын гэрчилгээ олгогдсоноос бусад тохиолдолдэнэ дүрмийн шаардлагад хамаарах аэродромын үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно.
- (b) Аэродромын гэрчилгээтэй байх шаардлагагүй аэродромын үйл ажиллагаа эрхлэгчгэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргаж болно.

139.5А Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигчид тавигдах шаардлага

- (a) Энэ дүрэм нь Даргын, 139.23–ын шаардлагыг хангасан гэж тодорхойлсон аэродромд хамаарна.
- (b) Иргэний нисэхийн тухай хууль болон энэ дүрмийн шаардлагыг хангажДаргын бүрэн эрхийн хүрээндАэродромын хязгаарлагдмалгэрчилгээ олгогдсоноос бусад аливаа этгээд аэродромын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.
- (c) Аэродромын хязгаарлагдмалгэрчилгээтэй байх шаардлагагүй аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргаж болно.

139.7 Өргөдөл гаргах

- (a) Аэродромын гэрчилгээ, эсхүл Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь:
- (1) энэ дүрэмд заасны дагуу ИНЕГ-ын даргад өргөдөл ирүүлнэ;
 - (2) холбогдох өргөдлийн хураамжийг төлсөн байна.
- (b) Өргөдөлд доорх баримт бичгийг хавсаргана:
- (1) бүрэнгүйцэд бөглөсөн Өргөдлийн маягт;
 - (2) 139.77–д шаардсан Аэродромын гэрчилгээ эзэмшигчийн, эсхүл 139.417-д шаардсан хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигчийнЕрөнхий заавриналь хамаарахыг;
 - (3) бүртгэгдсэн байр зүйн зураглаачаар баталгаажуулсан аэродромын болон түүний байгууламжийн дэвсгэр зураг;
 - (4) тухайн газрыг аэродромын зориулалтаар ашиглаж болохыг гэрчлэх хууль ёсны баримт нотолгоо.
- (c) Өргөдлийг Гэрчилгээ шаардагдахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө Даргад ирүүлсэн байна.

139.9 Гэрчилгээ олгох

- (a) Дарга, 139.7–д заасны дагуу өргөдөл гаргасанэтгээдэд Аэродромын гэрчилгээ,эсхүл Аэродромынхязгаарлагдмал гэрчилгээ олгож болно.

(b) Хуульд заасан шалтгаан нь энэ дүрмийн Б Бүлэг,эсхүл Ж Бүлэгт тогтоосон холбогдох шаардлагуудын хамаарах заагдсан шаардлагуудболно.

(c)Дарга Аэродромынхязгаарлагдмал гэрчилгээолгохдоо 139.21–д шаардсан нисэхийн судалгаагаартодорхойлсон эрсдлүүдэд анхаарал хандуулах, аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн мөрдөж ажиллах аливаа үйл ажиллагааны журмыг тогтоох, эсхүл аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн мөрдөж ажиллах аливаа шаардлагыг тавьж болно.

139.11 Гэрчилгээний хүчинтэй хугацаа

(a) Дарга,аэродромын гэрчилгээ, эсхүл аэродромын хязгаарлагдмал гэрчилгээний хугацааг гэрчилгээ олгосон өдрөөс хойш 5 жилээс дээш хугацаагаар тогтоохгүй.

(b) [Хүчингүй]

(c) [Хүчингүй]

(d) [Хүчингүй]

139.13 Гэрчилгээг дахин олгох

(a) Аэродромын гэрчилгээ,эсхүл аэродромынхязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ эзэмшигчийн эрхээ үргэлжлүүлэхийг хүссэн нөхцөлд гэрчилгээний хугацаа дуусахаас өмнө шинэ гэрчилгээ авахаар 139.7–ийн дагуу өргөдөл гаргана.

(b) 139.7(c)-д заасныг үл харгалзан, шинэ гэрчилгээ хүссэн өргөдлийг гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 60–аас доошгүй хоногийн өмнө Даргад ирүүлсэн байх шаардлагатай.

139.15 Нөөц

139.17 Дүрмийн шаардлагаас гажих

(a) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хүний амь нас, эсхүл өмч хөрөнгийг аврах, хамгаалах зайлшгүй, яаралтай ажиллагаа шаардсан онцгой нөхцөл байдал үүссэн үед энэ дүрмийн В, эсхүл Г Бүлэгт заагдсан аливаа шаардлагаас гажиж болно.

(aa) Аэродромын хязгаарлагдмалгэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хүний амь нас, эсхүл өмч хөрөнгийг аврах, хамгаалах зайлшгүй яаралтай ажиллагаа шаардсан онцгой нөхцөл байдал үүссэн үед энэ дүрмийн Ж, эсхүл З Бүлэгт заагдсан аливаа шаардлагаас гажиж болно.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)–д зааснаар энэ дүрмийн В, эсхүл Г Бүлгийн, (aa)–дзааснаар Ж, эсхүл З Бүлгийн аливаа шаардлагаас гажсан бол онцгой нөхцөл байдал тохиолдсоноос хойш 14 хоногийн доторДаргад албан бичгээр тайлбар, тайлан ирүүлсэн байна.

(с) Энэзүйлийн (b) хэсэгт заасан тайланд дүрмийн шаардлагаас гажсан үйл явдал, шалтгаан, цар хүрээ, хугацаа зэргийг тодорхой заасан байна.

139.19 Гэрчилгээгүй аэродромд тавигдах шаардлага

Аэродромын гэрчилгээ, эсхүл Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигчээс бусад аэродромынүйл ажиллагаа эрхлэгч ньэнэ дүрмийн И Бүлэгт заасан шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

AA Бүлэг— Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээний нөхцлийг тодорхойлох

139.21 Нисэхийн судалгаа

(a) Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчнь Аэродромын гэрчилгээ, эсхүл Аэродромын хязгаарлагдмалгэрчилгээ эзэмшигч биш бол Дарга дараах тохиолдолд нисэхийн судалгаа хийлгэхийг шаардаж болно. Үүнд:

- (1) Дарга, ихээхэн хэмжээний өөрчлөлт орсон гэж үзсэн, эсхүл аэродромыг ашиглах, эсхүл үйл ажиллагаа явуулахад нөлөөлөхүйц тодорхой шалтгаан байна гэж үзсэн, эсхүл
- (2) аливаа этгээдээс шалтгаалан нисэхийн аюулгүй ажиллагаанд тодорхой хэмжээний эрсдэл, нөлөө үзүүлэх, эсхүл
- (3) Дарга 157.11(a)(2)–т заасны дагуу нөхцөл заасан шийдвэрийг доорхи зүйлүүдтэй холбоотой гаргасан бол:
 - (i) энэ зүйлийн (a)(1)–дзаасан өөрчлөлт орсон, эсхүл
 - (ii) энэ зүйлийн (a)(2)–тзаасан, анхаарал татах, **санаа зовох** зүйл байгаа, эсхүл
- (4) Дарга 157.11(a)(3)–д заасны дагуу, доорхи зүйлүүдтэй холбоотойтатгалзсан шийдвэр гаргасан бол:
 - (i) энэ зүйлийн (a)(1)–д заасан зүйлүүд өөрчлөгдсөн, эсхүл
 - (ii) энэ зүйлийн (a)(2)–тзаасан анхаарал татах, **санаа зовох** зүйл байгаа, эсхүл

(b) Энэ зүйлийн (a)(1)–д заасан томоохон өөрчлөлт гэдэгт дараах зүйлүүд багтана:

- (1) дараахонгоцоор агаарын тээврийн тогтмол үйл ажиллагаа явуулж эхэлсэн, эсхүл санал тавьсан:
 - (i) гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 9–өөс дээш зорчигчтой, эсхүл
 - (ii) ашигт ачаалал нь 3410кг, эсхүл түүнээс бага ба гэрчилгээжсэн хөөрөлтийн хамгийн их жин нь 5700кг–аас их, эсхүл

- (iii) SEIFR буюу нэг хөдөлгүүртэй онгоцоор, ил харааны нислэгийн дүрмээрзорчигч тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх, эсхүл
 - (2) аэродром дахь агаарын хөлгийн хөдөлгөөн эрс нэмэгдсэн, эсхүл
 - (3) ашиглаж буй агаарын хөлгийн маягт, эсхүл эрхэлж буй агаарын хөлгийн үйл ажиллагааны төрөлд томоохон өөрчлөлт орсон, эсхүл
 - (4) аэродромын бодит үзүүлэлтүүдэд томоохон өөрчлөлт орсон, эсхүл
 - (5) аэродромын орчимд,эсхүл аэродром дээрхосол, эсхүл зөрчлийн тоо нэмэгдсэн, эсхүл
 - (6) агаарын хөлгийн жилийн хөдөлгөөний тоо үргэлжилсэн 3 жилийн дотор ихэссэн:
 - (i) 40,000, эсхүл түүнээс дээш ИХНДболонХНД-ийн нэгтгэсэнхөдөлгөөн; эсхүл
 - (ii) 7,500, эсхүл үүнээс дээшХНД-ийнхөдөлгөөн; эсхүл
 - (iii) 60,000, эсхүлүүнээс дээш ИХНДболонХНД-ийнхөдөлгөөнийг нэгтгэнтооцсоны 9,000, эсхүл түүнээс олон ХНД-ийнхөдөлгөөн бүртгэгдсэн, эсхүл
 - (iv) 15,000, эсхүлтүүнээс олон ХНД-ийнхөдөлгөөн; эсхүл
 - (v) 100,000, эсхүлнэгтгэн тооцсонИХНДболонХНДхөдөлгөөн.
- (c) Хэрэв Дарга нисэхийн судалгаа хийлгэхийг шаардсан болтухайн шаардлага нь:
- (1) албан бичгээр байна;
 - (2) шаардлагын шалтгааныг тогтоосон байна;
 - (3) шаардлагатайнисэхийн судалгааны ажлын зорилгыг тодорхойлсон байна;
 - (4) нисэхийн судалгаа хийгдэж дууссан байх огноог заасан байна.
- (d) Даргаас нисэхийн судалгаа хийлгэх шаардлага хүлээн авсан этгээд нь:
- (1) Даргын шаардлагатай гэж үзсэн байгууллага, бүлгийн төлөөлөл, үйлдвэрлэлийн төлөөлөл зэрэгтэй санал солилцох, зөвлөлдөх үүрэгтэй;
 - (2) Нисэхийн судалгаагаар дараах зүйлүүдийг тодруулна:
 - (i) аэродромын дизайн, төлөвлөлтийн нөлөө, эсхүл түүнийг ашиглахад агаарын хөлөгт аливаа аюулгүй, үр дүнтэй ашиглах боломжтой байх, газар дээрхи хүний болон эд хөрөнгийн аюулгүй ажиллагааг хангаж байхыг
 - (ii) одоо байгаа болон санал болгон дэвшүүлж буй эрсдлийг бууруулах хэмжүүр үзүүлэлтүүд, арга хэмжээнүүд
 - (3) Хүсэлт гаргахад тодорхойлсон хугацаа дуусахаас өмнө Даргад нисэхийн судалгааны тайланг ирүүлсэн байх

(е) Аэродромын үйл ажиллагаа аюулгүй явагдаж буйд үнэлгээ хийхэд шаардагдах хангалттай мэдээлэл тухайн судалгаанд хангалтгүй байна гэж ИНЕГ-ын дарга үзсэн нөхцөлд тухайн этгээдээс нэмэлт мэдээлэл шаардаж болно.

(f) Нисэхийн судалгаа хийж буй этгээд ИНЕГ-ын даргын шаардсан нэмэлт мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

139.23 Хязгаарлагдмал гэрчилгээтэй аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийг шийдвэрлэх

(a) Уг дүрмийн 139.21(d)(3) –д шаардсан нисэхийн судалгаа ирүүлснийг хүлээн авсны дараа ИНЕГ-ын дарга нисэхийн аюулгүй ажиллагаанд учрах эрсдлийн түвшинг уг зүйлийн (b) хэсэгт шаардсаны дагуу үнэлж, сайтар судлан, тухайн аэродром нь хязгаарлагдмал аэродромын эрх хэмжээнд ажиллах боломжтой гэж үзвэл хязгаарлагдмал аэродром гэдгийг тодорхойлж шийдвэр гаргана.

(b) Шийдвэр гаргахын өмнө ИНЕГ-ын дарга доорхи зүйлүүдийг хийсэн байх шаардлагатай.

(1) Дор дурдсан зүйлүүдийг харгалзан үзэж, тухайн аэродромын үйл ажиллагаа нь нисэхийн аюулгүй ажиллагаанд учрах эрсдлийг үнэлэхийн тулд аюулгүй ажиллагааны хяналт хийх шаардлагатай

(i) Энэ дүрмийн 139.21 –д заагдсан одоо байгаа болон санал болгож буй бүх эрсдлийг бууруулах арга хэмжээг тусгасан нисэхийн судалгааг үндэслэн

(ii) тухайн аэродромтой холбоотой бүх эрсдлийг тогтоосон байх

(iii) Энэ дүрмийн 139.21 б-д хамаарах хүчин зүйлүүд

(iv) бусад холбоотой аливаа мэдээллүүд

(2) Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй дор дурдсан асуудлаар зөвлөлдөнө.

(i) хэрэв аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нисэхийн аюулгүй ажиллагаанд оршиж болох эрсдлийг бууруулж чадах эсхүл нисэхийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх бүх эрсдлийг арилгаж чадах эсэхийг тодорхойлсон байна.

(ii) Энэ зүйлийн Бүлэг (2)(i) –д тодорхойлсон үйлдэл, нисэхийн аюулгүй ажиллагаанд учрах эрсдлүүдийг шийдвэр гаргах шаардлагагүй түвшинд хүртэл бууруулж, удирдан зохион байгуулсан эсэхийг тодорхойлсон

(3) ИНЕГ-ын дарга тухайн шийдвэрийг гаргахад нөлөөтэй, шаардлагатай гэж үзвэл агаарын тээврийн салбарын болон бусад талын оролцогчидтой зөвлөлдөнө.

(с) Энэхэсгийн (b)(1)(i) –дзаасны дагуу ИНЕГ-ын дарга энэ дүрмийн 139.21-д шаардсан нисэхийн судалгааны оронд ИНД - 157 –р дүрмийн шаардлагын дагуу бэлтгэсэн нисэхийн судалгааг ашиглахыг шаардаж болно.

139.25 Шийдвэрийг хүргүүлэх

ИНЕГ-ын дарга аль болох түргэн хугацаанд шийдвэр гаргасны дараа аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид албан бичгээр доорхи зүйлсийг багтаан хандах ёстой. Үүнд:

- (1) шийдвэр
- (2) шийдвэрийн хүчин төгөлдөр болох хугацаа, огноо
- (3) шийдвэр гаргасан шалтгаан
- (4) Хуульд заасан эрхийн дагуу аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийнгомдол гаргах эрх

139.27 Шийдвэрийн хүчинтэй болох хугацаа

ИНЕГ-ын даргын шийдвэрт тусгагдсан өдрөөс эхлэн уг шийдвэр хүчин төгөлдөр болно.

139.29 Шийдвэрээ цуцлах

(а) аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн хүсэлтийн дагуу ИНЕГ-ын дарга шийдвэрээ цуцалж болно. Энэ дүрмийн 139.23 а –д заагдсан, шийдвэр гаргахад баримталсан шалгуур үзүүлэлтүүд хангалтгүй, тухайн аэродром нь цаашид аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигчийн эрх үүргийн хүрээнд ажиллах шаардлагагүй гэж ИНЕГ-ын дарга үзсэн нөхцөлд гаргасан шийдвэрээ цуцалж болно.

(b) ИНЕГ-ын даргад Энэ дүрмийн 139.23 а –д заагдсан, шийдвэр гаргахад баримталсан шалгуур үзүүлэлтүүд хангалтгүй, тухайн аэродром нь цаашид аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигчийн эрх үүргийн хүрээнд ажиллах шаардлагагүй гэдгийг нотлон үзүүлэхнь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг болно.

(с) Шийдвэрийн цуцлалт нь ИНЕГ-ын даргын заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

ББүлэг— Гэрчилгээжүүлэлтийн шаардлагууд

139.51 Аэродром төлөвлөлтийн шаардлагууд

(a) Аэродромын гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч нь тухайн аэродромын бодит үзүүлэлтүүд, саадаас хязгаарлах гадаргуу, ил харааны хэрэгслүүд, тоноглолууд, саадыг тэмдэглэх болон хязгаарлагдсан бүс, тоног төхөөрөмж, суурилагдсан зэрэг нь шаардлага хангагдсанд итгэлтэй байх шаардлагатай.

- (1) Тухайн аэродромд ашиглагдах агаарын хөлгийн үзүүлэлтэд тохирсон
- (2) ХБЗ тус бүрд тогтоосон цаг агаарын доод минимум
- (3) ХБЗ бүрд агаарын хөлгийн ашиглах гадна гэрлийн нөхцөл

(b) Аэродромын гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч нь хэрэв аэродромын ХБЗ-ны төгсгөл бүрд байх ТАЗ нь энэ дүрмийн А.1 хавсралтад шаардсан стандартын дагуу бодит үзүүлэлттэй байх шаардлагыг доорхи аэродромууд хангасан байхыг бататгасан байна. Үүнд:

- (1) Олон улсын байнгын нислэгт ашиглагдах Монгол улсаас эхлэлтэй эсхүл төгсгөлтэй нислэгт ашиглах бол, эсхүл
- (2) 2006 оны 10 –р сарын 12 –ноос хойш аэродромын гэрчилгээ анх удаа олгогдсон ба нисгэх багийн суудлыг тооцохгүйгээр 30 –аас дээш суудал бүхий онгоцоор тогтмол агаарын тээвэрлэлт хийдэг бол, эсхүл
- (3) 2006 оны 10 –р сарын 12 –оос хойш ашиглалтанд орсон, нисгэх багийн суудлыг тооцохгүйгээр 30 –аас дээш суудал бүхий онгоцоор тогтмол агаарын тээвэрлэлт хийдэг, эсхүл
- (4) нисгэх багийн суудлыг тооцохгүйгээр 30 –аас дээш суудал бүхий онгоцоор тогтмол агаарын тээвэрлэлт хийдэг бол -
 - (i) Буултын боломжит зайг, эсхүл нислэгийн зурвасны уртыг 2006 оны 10-р сарын 12 –ны өдрөөс өмнө зарлагдсан байсан тухайн хэмжээнээс 15 м –ээс илүү зайд эсхүл түүнээс урт хэмжээгээр нэмэгдүүлсэн, эсхүл
 - (ii) ХБЗ нь 2006 оны 10-р сарын 12 –ноос хойш хэрэглэлийн нислэгт ашиглах тоноглолоор тоноглогдсон бол

(c) Аэродромын ТАЗ нь ИНЕГ-ын даргын шаардлагад нийцсэн байна.

(d) Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч тухайн аэродромын бодит үзүүлэлтүүд, саадаас хязгаарлах гадаргуу, тэмдэгт тэмдэглэгээ, тоног төхөөрөмж, суурилагдсан объект нь доор дурдсан шаардлагыг хангасан байхыг бататгана. – үүнд: An applicant for the grant of an aerodrome operator certificate must ensure that the physical characteristics, obstacle limitation surfaces, visual aids, equipment and installations, provided at the aerodrome are—

- (1) Доорхи дүрмийн заалтуудыг биелүүлсэн ба—

- (i) Хавсралт С; ба
- (ii) Хавсралт D; ба
- (iii) Хавсралт I –н I.1, I.2, баI.3 –р зүйлүүд; ба
- (iv) ХавсралтE -н E.4 –р зүйлийг 2018 оны 7-р сарын 31-ээс хойш; ба
- (v) Хавсралт F; ба
- (vi) Хавсралт G; ба
- (vii) Хавсралт H 2018 оны 7-р сарын 31-ны дараа; ба

(2) ИНЕГ-аар хүлээн зөвшөөрөгдсөн байна..

(е) Энэ зүйлийн (d) хэсэг нь нэг эсхүл түүнээс олон онгоц аэродромын зөвхөн тухайн хэсгийг ашиглаж байгаа бол хамаарна.

(1) Тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд зоиулагдсан бөгөөд хэрэв—

- (i) тухайн агаарын хөлгийн хөөрөх цэг Монгол улсын гадна боловч Монгол улсад буух бол, эсхүл
- (ii) тухайн агаарын хөлгийн буух цэг Монгол улсын гадна орших боловч, хөөрөх цэг Монгол улсад бол

(2) Зорчигч тээвэрлэх агаарын тээврийн тогтмол үйл ажиллагаа явуулах, 30 – аас дээш зорчигчийн суудалтай үйлдвэрээс гэрчилгээжсэн онгоцонд үйлчлэх бол

139.53 Аэродромын хязгаарлалтууд

Аэродромын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч аэродром дахь агаарын хөлгийн аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу, хэрэв зайлшгүй шаардлагатай бол, тухайн аэродромын дизайн, төлөвлөлт, эсхүл байгууламж, эсхүл үзүүлж буй үйлчилгээнээс үүдсэн аэродромыг ашиглах тодорхой хязгаарлалтуудыг тогтоосон байна.

139.55 Ажилтнуудад тавигдах шаардлага

(а) Аэродромын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь дор дурдсан ажилтнуудыг ажиллуулсан,гэрээлсэн эсхүл хөлслөн авч ажиллуулсан байна.

(1) ерөнхий захирлаар нэр дэвшсэнудирдах албан тушаалтан нь:

- (i) Өргөдөл гаргагч байгууллагын бүх үйл ажиллагаа нь энэ дүрмийн стандарт, шаардлагыг биелүүлэн дүрмийн шаардлагын хүрээнд явагдаж, санхүүжиж байгааг бататгаж, эрх мэдэл бүхий байна.
- (ii) Энэ дүрмийн стандарт шаардлагыг өргөдөл гаргагч байгууллага биелүүлжбайгааг бататган, хариуцлага хүлээсэн байна.

(2) Нисэх буудлын менежерээр томилохоор төлөвлөж байгаа удирдах албан тушаалтан эсхүл удирдах албан тушаалтнууд нь:

(i) аэродромын байгууламж ба түүний үйл ажиллагаа энэ дүрмийн бүлэг А –D д заагдсан шаардлагатай нийцэж байгааг бататган, хариуцлага хүлээсэн байна.

(ii) Энэ дүрмийн 139.75 –р зүйлд шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны хариуцлагыг хүлээсэн байна.

(iii) Ерөнхий захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээсэн байна.

(3) аэродром ба түүний үйлчилгээ, байгууламж нь уг дүрмийн Бүлэг А -аас D – д заагдсан шаардлагын дагуу үйл ажиллагаа, ашиглалт, арчлалтын ажил явуулах хангалттай тооны ажилтнуудтай байна.

(aa) Энэ зүйлийн (a)(2)(ii) -д заасан удирдах албан тушаалтан гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвар, туршлагыг нотлох боломжтой байна.

(b) Аэродромын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь тухайн аэродром, түүний үйлчилгээ, байгууламжийг ашиглах, арчлах, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай ажилтнуудын мэргэшлийн ур чадварыг эхлэн тогтоох, үнэлэх, үргэлжлүүлэн хадгалах журамтай байна.

139.57 Аэродромын онцгой байдлын төлөвлөгөө

(a) Аэродромын гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч нь тухайн аэродромд, эсхүл аэродромын ойролцоо онцгой байдал үүсч, хүний амь нас, эд хөрөнгөнд учирч болох хохирлын цар хүрээ, хэмжээг багасгахад зориулан бэлтгэсэн аэродромын онцгой байдлын төлөвлөгөөг боловсруулан хэрэглэж, ашигладаг байна.

(b) аэродромын онцгой байдлын төлөвлөгөөнд дараахи зүйлсийг оруулсан байна. Үүнд:

(1) тохиолдож болох онцгой байдлын төрлүүдийн нарийвчилсан жагсаалт

(2) онцгой байдлын үед төлөвлөгдсөн шуурхай үйл ажиллагаа, авах арга хэмжээний журам

(3) төлөвлөгөөг хэрэгжүүлэх гүйцэтгэх үүрэг бүхий ажилтан бүрийн үүрэг хариуцлагыг нарийвчлан заасан дэлгэрэнгүй заавар

(4) төлөвлөгөөнд хамрагдаж байгаа агентлагууд \ байгууллагууд \ тус бүрийн хийх ажил, үүрэг хариуцлага

(5) энэ дүрмийн 139.5 (aa)(1)-д заасан аэродромын хувьд хангалттай тоноглогдсон онцгой байдлын удирдлагын төв болон онцгой байдлын төрөл бүрд тохирсон удирдлагын цэг

- (6) эмнэлгийн тоног төхөөрөмжийг оролцуулаад онцгой байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдахбэлэн байгаа тоног төхөөрөмжийн жагсаалт, тодорхойлолт, тэдгээрийн байрлалын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл
- (7) тодорхой онцгой байдал үүсэхэд холбоо барих хүмүүс, байгууллагын нэр, утас гэх мэт мэдээллийг агуулсан жагсаалт
- (8) тухайн аэродромын болон түүний ойролцоох газар нутгийг багтаасан

торлосон зураг

- (9) 139.109-р зүйлийн дагуу аэродромын онцгой байдлын төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийг хангах журамтай байна.

(с) Өргөдөл гаргагч нь:

(1) [хүчингүй]

- (2) аэродромын онцгой байдлын төлөвлөгөөг баяжуулах, шинэчлэх ажилд хамааралтай бүх этгээд, байгууллагууд, ажилтнуудын оролцоог хангаж, **БОЛОМЖИТ** хэмжээнд хүргэсэн байна.

139.59 Аврахгал унтраах зэрэглэл тогтоох

(а) Энэ зүйлийн догол мөр (b) –д зааснаас бусад тохиолдолд, энэ дүрмийн 139.5(аа)(1) –д заасан аэродромын гэрчилгээ хүсч өргөдөл гаргагчньаврахгал унтраах зэрэглэлийг тухайн аэродромыг байнга ашиглах хамгийн том агаарын хөлгийн маягийн дагуу хүснэгт 1-д зааснаартогтоосон байна.

Хүснэгт 1. Аэродромын аврах, гал унтраах зэрэглэл

Аэродромын зэрэглэл	Онгоцны нийт урт	Их биеийн хамгийн их өргөн
3	12 м – 18 м хүртэл, гэхдээ 18 м орохгүй	3 м
4	18 м – 24 м хүртэл, гэхдээ 24 м орохгүй	4 м
5	24 м – 28 м хүртэл, гэхдээ 28 м орохгүй	4 м
6	28 м – 39 м хүртэл, гэхдээ 39 м орохгүй	5 м
7	39 м – 49 м хүртэл, гэхдээ 49 м орохгүй	5 м
8	49 м – 61 м хүртэл, гэхдээ 61 м орохгүй	7 м
9	61 м – 76 м хүртэл, гэхдээ 76 м орохгүй	7 м
10	76 м – 90 м хүртэл, гэхдээ 90 м орохгүй	8 м

1.Тухайн аэродромыг байнга ашиглах хамгийн том агаарын хөлгийн маягийн дагуу зэрэглэл тогтоохдоо эхлээд онгоцны нийт уртыг, дараа нь их биеийн хамгийн их өргөний хэмжээг харгалзана.

2. Хэрэв онгоцны нийт уртыгхаргалзан зэрэглэлийг сонгосны дараа их биеийн өргөний хэмжээ 3-р баганад үзүүлсэн тухайн зэрэглэлийн хамгийн их хэмжээнээс их байвал, тухайн зэрэглэлийг нэг зэрэглэлээр дээшлүүлэн тогтооно.

(b) Энэ зүйлийн (a)–д заасны дагуу тодорхойлсон аэродромын зэрэглэлийг бууруулж болно:

(1) хэрэв аливаа 12 сарын хугацаанд, үргэлжилсэн оргил ачааллын 3 сард энэ зүйлийн (a)-д заасны дагуу тухайн аэродромын зэрэглэлийг тогтоосон онгоцны хөдөлгөөн нь 700-аас бага бол нэг зэрэглэлээр, эсхүл

(2) Дараах нөхцөлд хоёр зэрэглэлээр:

(i) хэрэв аливаа 12 сарын хугацаанд, үргэлжилсэн оргил ачааллын 3 сард энэ зүйлийн (a)-д заасны дагуу тухайн аэродромын зэрэглэлийг тогтоосон онгоцнуудын хөдөлгөөн нь 700-аас бага бол

(ii) 3, эсхүл түүнээс дээш тооны зэрэглэлийн зөрүү энэ зүйлийн (a) –д заасны дагуу тодорхойлсон онгоцны хэмжээний хязгаар, ашиглаж буй онгоцны хооронд байвал

(c) Энэ зүйлийн (a)-д зааснаас бусад аэродромын гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч Аврах гал унтраах зэрэглэлийг дараахи байдлаар тогтоосон байна:

(1) хэрэв тухайн аэродром гэрчилгээжсэн 30–аас дээш суудалтай аливаа сэнст тийрэлтэт эсхүл турбинт тийрэлтэт онгоцоор агаарын тээврийн тогтмол үйлчилгээ үзүүлдэг бол, тухайн аэродромыг байнга ашиглах хамгийн том агаарын хөлгийн маягийн дагуу хүснэгт 1-д үзүүлсэн гал унтраах зэрэглэл тогтоох ба уг зэрэглэлийг хоёр зэрэглэлээр бууруулж болох ба гэхдээ ямарч тохиолдолд 4-р зэрэглэлээс доошгүй байна.

(2) Хэрэв тухайн аэродром энэ зүйлийн (c)(1)-д заасан аливаа турбинт тийрэлтэт эсхүл сэнст тийрэлтэт онгоцны төрлөөс ашигладаггүй ба гэхдээ турбинт тийрэлтэт биш эсхүл сэнст тийрэлтэт биш гэрчилгээжсэн 30 –аас дээш суудалтай онгоцоор агаарын тээврийн тогтмол үйлчилгээ үзүүлдэг ба эдгээр онгоцоор аливаа 12 сарын хугацаанд, үргэлжилсэн оргил ачааллын 3 сард 700-аас их хөдөлгөөн үйлдсэн бол аэродромын зэрэглэл 3 эсхүл түүнээс дээш байна.

(3) хэрэв энэ зүйлийн (1),эсхүл (2)-т зааснаар авран хамгаалах гал унтраах аэродромын зэрэглэл тодорхойлогдоогүй бол зэрэглэл хэрэглэхгүй.

139.61 Аврах гал унтраах бодис

139.111–д шаардсан авран хамгаалах гал унтраах хүчин чадалтай байх аэродромын гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч нь 139.59 –д заасан галын зэрэглэлд шаардлагатай, хамгийн багадаа Хүснэгт 2–т үзүүлсэн хэмжээтэй унтраах бодисыг байлгана.

Хүснэгт 2. Унтраах бодисын хамгийн бага хэрэглэх боломжтой хэмжээ

--	--	--	--

Аэродромын зэрэглэл	В түвшний шаардлагын хөөс		С түвшний шаардлагын хөөс		Нэмэгдэл / орлуулах бодис		
	Ус	Хөөс зарцуулалт / мин	Ус	Хөөс шахах ангилал / мин	Хуурай химийн бодис	Шахах ангилал	Эсхүл CO 2
	Литр	Литр	Литр	Литр	Кг	Кг/ сек	Кг
1	2	3	4	5	6	7	8
3	1200	900	820	630	135	2.25	270
4	2400	1800	1700	1100	135	2.25	270
5	5400	3000	3900	2200	180	2.25	360
6	7900	4000	5800	2900	225	2.25	450
7	12100	5300	8800	2800	225	2.25	450
8	18200	7200	12800	5100	450	4.5	900
9	24300	9000	17100	6300	450	4.5	900
10	32300	11200	22280	7900	450	4.5	900

Тайлбар:

1. Эзлэхүүний нэгж нь литрээр ба жингийн нэгж нь килограмаар илэрхийлэгдэнэ.
2. Багана 2 ба 4 –д үзүүлсэн усны хэмжээ нь өгөгдсөн зэрэглэлд тохирох онгоцны нийт уртын дундаж хэмжээнд үндэслэсэн болно.

139.63 Аврах гал унтраах машин

(а) 139.111–д шаардсан аврах гал унтраах хүчин чадалтай байх аэродромын гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч 139.59-д тогтоосон аэродромын зэрэглэлийн Хүснэгт 3 –т шаардсан тооны аврах гал унтраах машиныг байлгана.

Хүснэгт 3. Аврах гал унтраах машины хамгийн бага тоо

ИНД 139.59 –р зүйлийн дагуу тодорхойлсон аэродромын зэрэглэл	Аврах гал унтраах машин
3	1
4	1
5	1
6	2
7	2
8	3
9	3
10	3

(б) Энэ зүйлийн (с) хэсэгт зааснаас бусад нөхцөлд (а) хэсэгт шаардсан машин бүр нь хоёр талын радио холбоогоор тоноглогдсон байна:

- (1) аэродром дахь бусад аврах гал унтраах машинтай
- (2) Аэродромын хяналтын үйлчилгээ эсхүл тухайн аэродромд үйлчилж буй нислэгийн мэдээллийн үйлчилгээтэй

- (3) Өргөдөл гаргагчийн онцгой байдлын төлөвлөгөөнд тодорхойлсон бусад галын депотой.
- (c) Энэ зүйлийн (b) хэсгийг үл харгалзан, дараах тохиолдолд авран хамгаалах гал унтраах машиныг хоёр талын холбоогоор тоноглохыг шаардахгүй:
- (1) Зөвхөн нэг машин шаардлагатай бол
 - (2) Аэродромын хяналтын үйлчилгээ эсхүл тухайн аэродромд үйлчилж буй нислэгийн мэдээллийн үйлчилгээ байхгүй бол
 - (3) Тухайн аэродромын онцгой байдлын төлөвлөгөөнд бусад галын депотой холбоотой байхыг тусгаагүй / шаардаагүй / бол.
- (d) Энэ зүйлийн (a)-д шаардсан машин бүр нь:
- (1) анивчдаг, эсхүл эргэлддэг маягтай байх
 - (2) нэг төрлийн улаан эсхүл шар –ногоон анхаарал татахуйц өнгөөр будагдсан байна.

139.65 Аврах гал унтраах бие бүрэлдэхүүнд тавигдах шаардлага

Энэ дүрмийн 139.111–д шаардсан аврах гал унтраах хүчин чадалтай байх аэродромын гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч тухайн аэродромын аврах гал унтраах бүх бие бүрэлдэхүүн доорхи шаардлагыг хангаж байгааг бататгасан журамтай байна.

- (1) бие бүрэлдэхүүн нь тэдгээрийн үүргээ гүйцэтгэх зориулалтын хамгаалалтын хувцас ба авран хамгаалах төхөөрөмжөөр хангагдсан тоноглогдсон байна.
- (2) сургалтанд хамрагдсан, эрүүл мэндийн ба бие бялдрын хувьд тохирсон, авран хамгаалах гал унтраах төхөөрөмжийг ашиглах хэрэглэх чадвартай байна.
- (3) ур чадвараа хадгалах байнгын дадлага болон давтан сургалтанд хамрагдах
- (4) аврах гал унтраах машин эсхүл машинууд ба төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулахад хангалттай тооны ажилтныг бэлэн байлгана.
- (5) Тэдний туслалцаа шаардагдах болж байгаа эсхүл айсуу онцгой байдлын үед дуут дохио, сэрүүлэг, эсхүл бусад хэлбэрийн дуудлагыг хүлээн авч бэлэн байна.

139.67 Аврах гал унтраах хариу үзүүлэх чадвар

Энэ дүрмийн 139.111 –д шаардсан аврах гал унтраах хүчин чадалтай байх аэродромын гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч, хэрэв ИНЕГ-ын дарга шаардсан бол, тухайн аэродромын алсын барааны харагдацын ба гадаргуугийн тохиромжтой нөхцөлд аврах гал унтраах дараахь хариу үзүүлэх чадварыг харуулсан байна.

- (1) эхний дуудлагаас хойш 3 минутын дотор уг дүрмийн 139.61 –р зүйлийн хүснэгт 2 –т шаардсан шахах ангиллаар хөөсний 50 % -ийг шахах боломжтой машин, бие бүрэлдэхүүн тогтоосон постоос хөдөлгөөний бүсийн хамгийн хол цэгт хөөсөө шахахаар хүрч очсон байна.
- (2) эхний хариу үзүүлснээс бусад аврах машин ба бие бүрэлдэхүүн уг дүрмийн 139.61-р зүйлийн хүснэгт 2 –т шаардсан аэродромын зэрэглэлийн унтраах бодисыг хүргэсэн байна.
 - (i) эхний дуудлага хүлээн авснаас хойш 4 минутаас ихгүй хугацаанд ирсэн байна.
 - (ii) Бие бүрэлдэхүүн унтраах бодис үргэлжлэн шахагдаж цацагдаж байхыг бататгана.

139.67A Аврах гал унтраах холбоо ба дуудлага хүлээн авах систем

- (a) Энэ зүйл нь 2018 оны 7-р сарын 31-ны өдрөөс хойш хэрэглэгдэнэ.
- (b) Уг дүрмийн 139.111 –д шаардсан авран хамгаалах гал унтраах хүчин чадалтай байх аэродромын гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч галын депог хяналтын цамхагтай, аэродром дахь бусад галын депотой, авран хамгаалах гал унтраах машинуудтай холбогдох тусдаа бие даасан холбооны системтэй байна.
- (c) Энэ зүйлийн (a) хэсэг нь 2018 оны 8-р сарын 1-ны өдрөөс эхлэн хүчингүй болно.

139.69 Олон нийтийн хамгаалалт

- (a) Аэродромын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч тухайн аэродромд доорхи шаардлагуудыг хангасан байна.
 - (1) Хөдөлгөөний бүс рүү санаандгүйгээр аливаа мал, амьтан нэвтрэн орохоос хамгаалсан байна.
 - (1A) Зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгсэл аэродромын үйл ажиллагааны бүс /нислэгийн талбай / рүү нэвтрэн орохоос сэргийлж, хамгаалсан байна.
 - (2) Онгоцны хөдөлгүүрийн үлээлтээс хүн, өмч хөрөнгийг хамгаалах боломжтой байна.
 - (b) 139.5 (aa)-д хамаарах аэродромын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь
- (a)(1) болон (a)(1A) –д шаардсан хамгаалалтыг хангасан байна:
- (1) Олон нийт тээврийн хэрэгсэл 8 эсхүл явган хүний зам руу шууд очих боломжтой аэродромын үйл ажиллагааны бүстэй залгаа орших талбайнуудад

- (i) Хяналттай, эсхүл харуул хамгаалалттай барилга, байгууламж, хаалга гарц бүхий үргэлжилсэн хаалт, хашлага
 - (ii) Багадаа1200 мм өндөртэй
- (2) Барилгын ажлын талбай болон өндрийн хэмжээнээс шалтгаалж мал амьтан нэвтрэн орж, онгоцны нислэгт аюул учруулж болзошгүй бусад газруудад

139.71 Мал, амьтан, шувууны аюулаас сэргийлэх, зохицуулалт

Аэродромын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч тухайн аэродромд нислэгийн үйл ажиллагаанд аюул саад учруулж болох аливаа мал, амьтан, шувууны аюул байвал уг аюулаас сэргийлэх, бууруулах эсхүл арилгах байгаль орчны менежментийн хөтөлбөртэй байна.

139.73 Аэродромын өгөгдөл ба мэдээллийг зарлан мэдээлэх

Аэродромын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад доорхи мэдээлэл өгөх үйл ажиллагааны журамтай байна:

- (1) Аэродромын өгөгдөл ба мэдээлэл
- (2) 139.53 –д заасны дагуу аэродромыг ашиглах талаархи тогтоосон аливаа хязгаарлалт байвал
- (3) Аэродромыг ашиглахад нөлөөлөх аливаа өөрчлөлт гарвал, аль болох түргэн хугацаанд

139.75 Аюулгүй ажиллагааны удирдлага

Аэродромын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч ИНД -100.3 дүрмийн дагуу тухайн аэродромд аюулгүй ажиллагааны системийг тогтоож, хэрэгжүүлж, үргэлжлэн хадгална.

139.76 Нислэгийн хөдөлгөөний мэдээ ирүүлэх

Аэродромын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагчнь тухайн аэродромын сарын нислэгийн хөдөлгөөнийг цуглуулж бүртгэх журамтай байх бөгөөд уг бүртгэл мэдээг ИНЕГ-ын даргад 3 сар тутам мэдээлж байна.

139.76А Аэродромд ажил хийгдэх

Аэродромын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагчнь тухайн аэродромд хийгдэх болон хийгдэж байгаа аливаа ажил нь агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюул,

эрсдэл учруулахгүй байх, аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ бүхий журамтай байна.

139.76В Баримт бичгийн хяналт

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч

- (1) Аэродромын байгууламж, үйлчилгээ ба үйл ажиллагаа, хангалтыг явуулахад зайлшгүй холбоотой баримт бичгийн хувийг байлгана.
- (2) Энэ зүйлийн дэд хэсэг (1) –д шаардсаныг бататгахын тулд баримт бичгийн хяналтын журамтай байна.
 - (i) Баримт бичиг ашиглах шаардлагатай ажилтнуудын ажлын байр бүрд холбогдох бичиг баримтын хүчин төгөлдөр хувийг байлгана.
 - (ii) Хуучирсан, хүчингүй баримт бичиг бүрийг гаргасан газар бүрээс нь түргэн устгасан байна.
 - (iii) Хүчин төгөлдөр бус, хуучирсан материал ашиглахаас сэргийлж баримт бичгийн хүчинтэй хувилбарыг тодорхойлох боломжтой байлгана.

139.77 Аэродромын гэрчилгээжүүлэлтийн заавар

(а) Аэродромын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь дор дурдсан зүйлийг агуулсан аэродромын зааврыг даргад ирүүлнэ.

- (1) Өргөдөл гаргагч байгууллагын нэрийн өмнөөс ерөнхий захирал гарын үсэг зурсан аэродромын заавар, зааварт багтаасан аливаа журам нь доорхи зүйлийг баталгаажуулсан
 - (i) Энэ дүрмийн шаардлагад нийцсэн хэрэгжиж байгааг бататгасан зохион байгуулалтыг тогтоосон ба аргачлал, арга хэрэгслийг үзүүлсэн
 - (ii) үйл ажиллагаанд байнга мөрдөж ажиллахаа нотолсон
- (1а) 139.75-р зүйлд шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоотой холбоотой
 - (i) ИНД -100.3 –д шаардсан бүх бичиг баримт
 - (ii) Аэродромын гэрчилгээ дахин олгохоос бусад өргөдөл гаргагч аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх талаар тайлбарласан хэрэгжүүлэх төлөвлөгөө

- (2) Удирдах албан тушаалтнуудын нэр, албан тушаалын жагсаалтыг энэ дүрмийн 139.55(а)(1) болон (2) –р зүйлд шаардсаны дагуу
- (3) 139.55(а)(1) ба 139.55(а)(2)-т шаардсан удирдах ажилтан эсхүл удирдах ажилтуудын хүлээх дор дурдсан үүрэг хариуцлага
 - (i) байгууллагын нэрийн өмнөөс хүлээсэн хариуцлагын дагуу дарга эсхүл ИНЕГ-тай шууд харьцах талаар
 - (ii) аюулгүй ажиллагааны удирдлагын талаархи үүрэг хариуцлага
- (4) 139.55(а)(1) ба 139.55(а)(2) -т шаардсаны дагуу удирдах ажилтнууд, эсхүл удирдах ажилтны хариуцлагын шугамыг харуулсан байгууллагын бүтэц, зохион байгуулалтын зураг
- (5) 139.53 –р зүйлд тогтоосон тухайн аэродромыг ашиглах талаархи аливаа хязгаарлалт
- (6) энэ дүрмийн Бүлэг А Б В эсхүл Г –ийн аливаа шаардлагуудаас өргөдөл гаргагчийг чөлөөлөх хүчин төгөлдөр чөлөөлөлт бүр
- (7) 139.57 –р зүйлд шаардсан аэродромын онцгой байдлын төлөвлөгөө
- (8) 139.59 –р зүйлийн шаардлагын дагуу тогтоосон аэродромын аврах гал унтраах зэрэглэл, 139.61, 139.63 ба 139.67А –т шаардсан бие даасан холбооны систем, галын машин, гал унтраах бодисын хэмжээ зэргийн тайлбар, 139.65 –р шаардсан ажилтнууд, үйл ажиллагааны журам, 139.111(с)(2) ба (3) –т шаардсан үйл ажиллагааны журам
- (9) 139.69 –т шаардсан олон нийтийг хамгаалах арга хэмжээний тайлбар
- (10) 139.71 –т хэрэв шаардсан бол байгаль орчны менежментийн хөтөлбөр
- (11) 139.73 –т шаардсан аэродромын өгөгдөл болон мэдээллийг зарлан мэдээлэх журам
- (12) \ Хүчингүй болсон \
- (12А) 139.76-р зүйлд шаардсан нислэгийн хөдөлгөөний өгөгдлийг цуглуулах, түүнийг мэдээлэх үйл ажиллагааны журам
- (13) 139.103 –р зүйлд шаардсан аэродром арчлалтын хөтөлбөр
- (14) 139.105 –р зүйлд шаардсан навигацийн зориулалттай ил харааны тоноглол, хэрэгслийг шалгах, болон урьдчилан сэргийлэх арчлалтын ажлыг явуулах журам
- (15) 139.76А –д шаардсан аэродром дахь аливаа ажил хийгдэх үеийн анхааруулга санамж, журам
- (16) [хүчингүй]болсон
- (17) Аэродромд үзлэг хийх хөтөлбөр, 139.117 –т шаардсан мэдээлэх журам

- (18) 139.119-р зүйлд шаардсангазрын үйлчилгээний машин, техникийн хяналтын журам
 - (19) 139.125 –д шаардсан аэродромд аюултай нөхцөл үүсэх үед агаарын хөлгийн үйл ажиллагааг хязгаарлах журам
 - (19А)139.76В(2)-д шаардсанаэродромын хангалт, үйл ажиллагаа явуулахад шаардагдах бичиг баримтын хяналт, зохицуулалтын журам
 - (20) 139.203(d)(8) ба (9)-р зүйлд шаардсан үйл ажиллагаа, аюулгүй байдлын үнэлгээ нөхцлийн дэлгэрэнгүй хөтөлбөр, журмыг агуулсан Бүлэг Д –н аюулгүй байдлын шаардлагуудыг биелүүлэх талаар авах арга хэмжээний тайлбар
 - (21) 139.205(с)-р зүйлд шаардсан аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр
 - (22) Аэродромын зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах, тараах журам
- (b) Өргөдөл гаргагчийн аэродромын заавар даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

В Бүлэг – Аэродромын үйл ажиллагааны шаардлагууд

101 Үргэлжлэн мөрдөж ажиллах

Аэродромын гэрчилгээ эзэмшигч—

- (1) Энэ дүрмийн 139.77 –р зүйлд шаардсан аэродромын бүрэн бүтэн, хүчин төгөлдөр зааврын нэг хувийг тухайн аэродром дээр байлгана.
- (2) Аэродромын зааварт дэлгэрэнгүй заасан хөтөлбөр, систем, төлөвлөгөө, үйл ажиллагааны бүх журмыг биелүүлнэ.
- (3) Тухайн ажилтнуудын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аэродромын зааврын хамаарах хэсэг бүрийг ажилтнуудад хүртээмжтэй байлгана.
- (4) Энэ дүрмийн БүлэгВ–д тогтоосон аэродромын гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлагыг биелүүлж, стандартад нийцүүлэн ажиллана.
- (5) үйлчилгээний хаяг, утасны дугаарын аливаа өөрчлөлт эсхүл ИНЕГ - 24139/01 маягтаар шаардсан бусад харилцах мэдээлэл өөрчлөгдвөл 28 хоногийн дотор даргад мэдэгдэнэ.

139.102 Төгсгөлийн аюулгүй зурвасын дүрмийн шилжилтийн шаардлага

[Хүчингүй болсон]

139.103 Аэродромын арчлалт

(а) Аэродромын гэрчилгээ эзэмшигч агаарын хөлгийн үйл ажиллагааг үр дүнтэй эсхүл аюулгүй, хамгаалагдсан, тогтмол үйл ажиллагаа явуулахад нөлөөлөхгүйгээр аэродромын байгууламжуудыг арчлах урьдчилан сэргийлэх арчлалтын ажлыг агуулсан тохирох арчлалтын ажлын хөтөлбөртэй байна.

(b) Арчлалтын ажлын хөтөлбөрт –

- (1) Агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюул учруулж болзошгүй аливаа биет, хаягдал, эсхүл сул объект, биет хучилттай маневрлах талбайн гадаргуу дээрээс цэвэрлэгдсэн байхыг хангах
- (2) Хучилттай ХБЗ-ны гадаргуугийн үрэлтийн итгэлцүүрийн үзүүлэлт сайн ба онгоцны дугуйн өнхрөхэсэргүүцэл бага байх нөхцлийг ханган арчлалтын ажлыг явуулах
- (3) 2018 оны 7-р сарын 31 –ээс хойш, стандартын дагуу мэдээлэх аргачлал ашиглан,ХБЗ бохирдолтой үед,гадаргуугийн нөхцлийгбодит байдлаар хэмжих, мэдээлэх

139.105 Навигацийн ил харааны тоноглолууд – шалгах, үзлэг хийх, засвар арчлалт явуулах

(а) Гэрчилгээ эзэмшигч тухайн аэродромд суурилагдсан наavigацийн тоноглолуудын арчлалтын ажлын хөтөлбөртэй байна.

(b) Арчлалтын ажлын хөтөлбөр доорхи зүйлүүдийг агуулсан байна.

- (1) Энэ дүрэмд тодорхойлсон хамаарах стандартын дагуу наavigацийн тоноглол бүр хэрэглэгчийг үнэн зөв баталгаатай зааварчилгаа, мэдээллээр хангаж байгааг бататгасан журамтай байна.
- (2) Хэрэглэгчийг зааварчилгаа, мэдээллээр үргэлжлэн хангаж байгааг бататгасан боловч гэрлийн систем бүрт ажиллахгүй, гэмтэлтэй байхыг зөвшөөрч болох гэрлийн тооны талаархи мэдээллэл
- (3) Аливаа гэмтсэн эсхүл ажиллахгүй болсон зүйлийгяаралтай ажилд оруулах, буцааж хэвийн болгох журам

139.107 Аэродром дээр хийгдэх ажлууд

[Хүчингүй]

139.109 Аэродромын онцгой байдлын төлөвлөгөө

Гэрчилгээ эзэмшигч:

- (1) Энэ дүрмийн 139.57–д шаардсан тухайн аэродромын онцгой байдлын төлөвлөгөөний дагуу ажил, үүрэг, хариуцлага хүлээсэн бүх ажилтнууд

өөрсдийн хийх ажил, үүрэг даалгаврыг мэддэг, зохих ёсны сургалтанд хамрагдсан байхыг бататгана.

(2) Энэ дүрмийн 139.57 –д шаардсанаэродромын онцгой байдлын төлөвлөгөөний сорилын аль нэгийг хийсэн байна.

(i) онцгой байдлын бүрэн хэмжээний дасгал сургуулилтын үед илрүүлсэн аливаа үл тохирол, зөрчлийг арилгаж, залруулсныг бататган, хоёр жилээс хэтрэлгүй давтамжаар аэродромын онцгой байдлын бүрэн хэмжээний дасгал сургуулилт, тэдгээрийн хооронд онцгой байдлын тусгай дасгал сургуулилтүүдийг хийх, эсхүл

(ii) Эхний жилээс эхлэн гурван жилийн хугацаанд хэсэгчилсэн сорилыг хэд хэдэн удаа явуулсан үед аэродромын онцгой байдлын бүрэн хэмжээний дасгал сургуулилтыг эхний хийгдсэнээс гурван жилээс хэтрэхгүй хугацаанд явуулах ба

3) дасгал сургуулилт бүрийн дараа төлөвлөгөөг эргэж харах, үнэлэх эсхүл, бодит ослын дараа эргэн харж, илэрсэн үл тохирол, зөрчлийг арилгах

(4) Энэ дүрмийн 139.57-д шаардсан онцгой байдлын төлөвлөгөөгтухайн аэродромын төлөвлөгөөнд үүрэг хүлээж буй хууль хүчний агентлагууд, аюулгүй байдал, аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгчид, АХГУАлбад, эмнэлгийн байгууллага, ажилтнууд, байнгын үндсэн түрээслэгчдийг оролцууланбүх байгууллага, хүмүүстэй харилцан зохицуулалт хийх

139.111 Аврах гал унтраах – үйл ажиллагаанд тавигдах шаардлага

(a) Энэ зүйлийн с хэсэгт шаардсанаас бусад, аэродромын гэрчилгээ эзэмшигч нь уг дүрмийн 139.61 ба 139.63-р зүйлд шаардсан минимум шаардлагуудыг үйл ажиллагаа явуулах үедээ тухайн аэродромын авран хамгаалах гал унтраах хүчин чадал, чадвар нь хангаж байхыг бататгана.

(1) гэрчилгээжсэн 30 –аас дээш зорчигчийн суудалтай онгоцоор зорчигч тээвэрлэхээр агаарын тээврийн тогтмол үйл ажиллагаа явуулах, эсхүл

(2) агаарын тээврийн тогтмол үйл ажиллагаа явуулах агаарын хөлөг

(i) тухайн агаарын хөлгийн хөөрөх цэг Монгол улсын гадна боловч Монгол улсад буух бол, эсхүл

(ii) Тухайн онгоцны буух цэг Монгол улсын гадна орших боловч, хөөрөх цэг Монгол улсад бол

(b) Энэ зүйлийн с хэсэгт зааснаас бусад аэродромын гэрчилгээ эзэмшигч нь Энэ дүрмийн 139.61ба 139.63-р зүйлд тодорхойлсон өндөр зэрэглэлд шаардсан минимум шаардлагыг биелүүлж аэродромын авран хамгаалах гал унтраах чадварыг дээшлүүлэхшаардлагатай. Хэрэв:

(1) нислэгийн тоо нэмэгдэх эсхүл аэродромд ашиглаж буй онгоцны маягт өөрчлөлт орох

(2) нислэгийн тоо нэмэгдэх эсхүл онгоцны маягт өөрчлөлт орох нь уг дүрмийн 139.59 –р зүйлд тодорхойлсны дагуу авран хамгаалах гал унтраах зэрэглэлийг дээшлүүлж байвал

(с) энэ зүйлийн (а) болон (b) зүйлийг үл харгалзан, аэродромын гэрчилгээ эзэмшигч нь тухайн аэродромыг ашиглаж буй агаарынхөлгийн хамгийн өндөр үзүүлэлтээр тооцсон шаардсан аэродромын зэрэглэлийг доорхи нөхцөлд бууруулж болно. Хэрэв:

(1) Энэ дүрмийн 139.59 –р зүйлийн дагуу аэродромын зэрэглэлийг тогтоосон онгоцны үзүүлэлтээс бага үзүүлэлт бүхий онгоц ашиглахаар тухайн аэродром хязгаарлагдсан бол

(2) Энэ дүрмийн 139.77 –р зүйлд шаардсан аэродромын зааварт зэрэглэл бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий хүмүүс, тэдгээрийн үйл ажиллагааны журам тусгагдсан бол

(3) Энэ дүрмийн 139.77 –р зүйлд шаардсан аэродромын зааварт тухайн аэродромын авран хамгаалах гал унтраах бүрэн чадварыг хүчингүй болгох журам тусгагдсан бол

(d) Гэрчилгээ эзэмшигч Энэ зүйлийн с хэсэгт заасан АХГУ хүчин чадлыг бууруулах ажлыг НМУБ –аас зарлан мэдээлэгдэх хүртэл хэрэгжүүлэхийг хориглоно.

(е) Энэ зүйлийн а хэсэгт шаардсан авран хамгаалах гал унтраах хүчин чадалтай байх аэродромын гэрчилгээ эзэмшигч машин бүрийн ашиглах хугацаанд хариу үзүүлэх хугацааг хангах, төхөөрөмжийн үр ашигтай ажиллагааг бататгахын тулд авран хамгаалах гал унтраах машин эсхүл машинуудын ашиглалтын урьдчилан сэргийлэх системийг тогтоосон байна.

(f) Энэ дүрмийн дагуу шаардлагатай авран хамгаалах гал унтраах машинажилгүй болж, гэрчилгээ эзэмшигч уг дүрмийн 139.67 –д заасан шаардлагыг ямар нэг хэмжээгээр биелүүлэх боломжгүй бол гэрчилгээ эзэмшигч :

(1) авран хамгаалах гал унтраах машиныг шаардлага хангасан машинаар нэн даруй солино.

(2) Хэрэв Энэ зүйлийн (f)(1) –р хэсэгт зааснаар нэн даруй солих боломжгүй бол уг дүрмийн 139.123 –р зүйлд заасны дагуу зарлан мэдээлнэ.

(3) Энэ дүрмийн 139.67-р зүйлд заасан хариу үзүүлэх чадвар буцаж хэвийн байдалд 72 цагийн дотор ороогүй, машин ажилгүй хэвээр бол тухайн хүчин чадалд тохирсон ажиллаж байгаа машин эсхүл машинуудын аэродромын зэрэглэлд тохирсон онгоцонд үйлчлэхээр хягаарлалт тогтооно.

(g) Энэ зүйлийн а хэсэгт заасны дагуу авран хамгаалах гал унтраах хүчин чадалтай байх гэрчилгээ эзэмшигч уг дүрмийн шаардлагад нийцсэн хүчин чадлаар а хэсэгт тодорхойлсон онцгой байдлын үйл ажиллагаа бүрдүр дүнтэй үйл

ажиллагаа явуулахаар сургагдсан бэлтгэгдсэн хангалттай бие бүрэлдэхүүн, авран хамгаалах гал унтраах тоног төхөөрөмжтэй ажиллан хариу үзүүлэх шаардлагатай.

139.113 Аэродром дахь нислэг хөдөлгөөний удирдлага

Гэрчилгээ эзэмшигч бүр дарга аюулгүй ажиллагааны эрх ашгийн үүднээс шаардсан бол тухайн аэродромд НМУ, эсхүл аэродромын удирдлага хяналтын үйлчилгээ, эсхүл аль аль нь байхыг бататгасан байна.

139.115 Перроны зохицуулалтын үйлчилгээ

(а) Гэрчилгээ эзэмшигч бүр тухайн аэродромын үйл ажиллагааны нөхцөл, нислэгийн хөдөлгөөний хэмжээ нь ийм үйлчилгээ шаардаж байвал зохих тохиромжтой перроны зохицуулалтын үйлчилгээ үзүүлэхийг бататгасан байна.

(b) Перроны зохицуулалтын үйлчилгээ бүхий гэрчилгээ эзэмшигчийн хяналтанд аэродромын хяналтын үйлчилгээг үзүүлж буй нэгж перроны зохицуулалтын үйлчилгээнд оролцдоггүй бол гэрчилгээ эзэмшигч нь аэродромын хяналтын үйлчилгээ, перроны зохицуулалтын үйлчилгээний нэгжийн хооронд онгоцыг шилжүүлэх зохицуулалтыг хийсэн байна.

139.117 Аэродромд үзлэг хийх хөтөлбөр

Гэрчилгээ эзэмшигч нь -

- (1) Энэ дүрмийн шаардлагын дагуу тухайн аэродром, түүний байгууламжууд ашиглагдаж буйг бататгахын тулд аэродромын үзлэгийн хөтөлбөртэй байна.
- (2) Аэродромд үзлэг хийхэд хэрэглэх тохиромжтой багаж, тоног төхөөрөмжөөр хангасан байна.
- (3) Аэродромд үзлэг хийж буй ажилтнууд холбогдох сургалтанд хамрагдсан байхыг бататгасан журамтай байна.
- (4) Аэродромын үзлэгийн үед илэрч тэмдэглэгдсэн аюултай нөхцөл байдлыг тухай бүрд нь шуурхай засахыг бататгасан мэдээллийн системтэй байна.

139.119 Газрын үйлчилгээний машин, тээврийн хэрэгсэл

(а) Гэрчилгээ эзэмшигч аэродромын үйл ажиллагааны бүсэд тээврийн хэрэгсэл, машин техник нэвтрэхийг хягаарлах болон хянах журамтай байна.

(b) Энэ зүйлийн а хэсэгт заасан журмын дагуу тухайн аэродромд шаардлагатай эсхүл онгоцны үйлчилгээнд зайлшгүй хэрэгтэй машин техникийг үйл ажиллагааны бүс рүү нэвтрүүлдэг байна.

(с) аэродромын хяналтын үйлчилгээтүхайн аэродромд ажиллаж буй нөхцөлд Энэ зүйлийн а –д шаардсан журам нь

- (1) газрын үйлчилгээний машин техник нь үйл ажиллагааны бүсэд ажиллах, уг бүс рүү аюулгүй дэг журамтай нэвтрэхийг хангах
- (2) маневрлах талбайд ажиллах машин техник бүрийн хөдөлгөөнийг хянахыг бататгасан байна.
 - (i) аэродромын хяналтын үйлчилгээба машин техник нь хоорондоо хоёр талын радио холбоотой байх, эсхүл
 - (ii) машин техник нь радио холбоогүй бол дагуулж чиглүүлж яваа машин техник нь аэродромын хяналтын үйлчилгээтэй хоёр талын холбоотой байх, эсхүл
 - (iii) хоёр талын радио холбоо боломжгүй, дагуулж чиглүүлж яваа машин техник тэмдэг, сигнал зэргээр тохирох арга хэмжээ авч , эсхүл тухайн машин техникийг хянах харуул гаргаж, эсхүл

(d) Аэродромын хяналтын үйлчилгээгүй аэродромд энэзүйлийн (а) –д шаардсан журмаар машин техник үйл ажиллагааны бүсэд ажиллахдаа тэмдэгт эсхүл урьдчилан тохиролцсон сигналаар зохицуулагдана.

(е) Энэ зүйлийн (а) хэсгээр шаардсан журмаар тухайн аэродромын үйл ажиллагааны бүсэд машин техник ашиглан ажил үүрэг гүйцэтгэж буй ажилтан, ажилчид, түрээслэгчид, эсхүл гүйцэтгэгч байгууллагын ажилтнууд бүр гэрчилгээ эзэмшигчийн тогтоосон газрын үйлчилгээний машин техникийн үйл ажиллагааны журмыг мэддэг, биелүүлдэг байхыг шаардана.

139.121 Нислэгийн Хөдөлгөөний Үйлчилгээний Байгууламж болон навигацийн тоног төхөөрөмжийг хамгаалах

Гэрчилгээ эзэмшигч нь-

- (1) агаарын хөдөлгөөний үйлчилгээний байгууламж, эсхүл ил харааны навигацийн, эсхүл, аливаа цахилгааны тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх бололцоотой аливаа барилга угсралтын эсхүл аливаа ажиллагааг тухайн аэродром дээр эсхүл гэрчилгээ эзэмшигчийн хяналтанд байдаг аэродром орчмын газартхийлгэхгүй байх шаардлагатай.
- (2) гэрчилгээ эзэмшигчийн эрх мэдлийн хүрээнд электроник, эсхүл ил харааны навигацийн хэрэгсэл, эсхүл агаарын хөдөлгөөний үйлчилгээний байгууламжийн аливаа тасалдал, доголдол гаргахыг зогсоох, урьдчилан сэргийлэх шаардлагатай.

139.123 Аэродромын байдлыг зарлан мэдээлэх

Гэрчилгээ эзэмшигч уг дүрмийн 139.73 –д шаардсан журмын дагуу агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж болох тухайн аэродромын үйл ажиллагааны аливаа нөхцөл байдлыг аль болох түргэн хугацаанд NOTAM мэдээ гарган, Нисэхийн Мэдээллийн Үйлчилгээ үзүүлэгч Байгууллагад мэдэгдэнэ.

139.125 Аюултай нөхцлүүд

Аэродромын гэрчилгээ эзэмшигч тухайн аэродромын аль нэг хэсэгт аюултай нөхцөл байдал үүссэн үед агаарын хөлгийн үйл ажиллагааг уг хэсэгт хязгаарлах, эсхүл шаардлагатай тохиолдолд хориглох зохицуулалтыг бататгасан журамтай байна.

139.127 Гэрчилгээ эзэмшигчийн зохион байгуулалтанд өөрчлөлт хийгдэх

(а) Аэродромын гэрчилгээ эзэмшигч бүр тухайн аэродромын заавар нь агуулга болон холбоотой байгууламж, үйлчилгээ, үйл ажиллагаа, хөтөлбөр, төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлтийн дагуу тайлбарлагдаж хадгалагдаж байгааг бататгасан байна.

(b) Гэрчилгээ эзэмшигч аэродромын зааварт аливаа нэмэлт өөрчлөлт оруулахад энэ дүрмийн холбогдох шаардлага, өөрийн аэродромын зааварт буй нэмэлт өөрчлөлт оруулах журамд нийцэж байгааг бататгасан байна.

(c) Гэрчилгээ эзэмшигч аэродромын зааварт нэмэлт өөрчлөлт оруулсныдараа нэмэлт өөрчлөлтийн бүрийн хувийг хадгалуулахаар даргад аль болох түргэнилгээнэ.

(d) Гэрчилгээ эзэмшигч доорхи асуудлын аль нэгэнд өөрчлөлт оруулахаас өмнө даргаар урьдчилан хүлээн зөвшөөрүүлсэн байхыг шаардана.

(1) Гүйцэтгэх Ерөнхий Захирал

(2) Жагсаалтад орсон удирдах ажилтнууд

(3) Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд оруулах бодитой өөрчлөлт

(е) Дарга Энэ зүйлийн (d) тогтоосон өөрчлөлтийн үед эсхүл өөрчлөлтийн дараа гэрчилгээ эзэмшигч үйл ажиллагаа явуулах нөхцлийг тогтоосон шаардлагыг тавьж болно.

(f) Гэрчилгээ эзэмшигч Энэ зүйлийн (е) –д тогтоосон Даргын шаардсан бүх нөхцлийг биелүүлэх үүрэгтэй.

(g) Хэрэв энэхүү дүрэмд хамаарах аливаа өөрчлөлт аэродромын гэрчилгээнд өөрчлөлт оруулахаар бол гэрчилгээ эзэмшигч Даргаар өөрчлөлтийг баталгаажуулахын тулд аэродромын гэрчилгээг аль болох түргэн ирүүлнэ.

(h) Дарга аюулгүй ажиллагааны эрх ашгийн үүднээс шаардлагатай гэж үзвэл гэрчилгээ эзэмшигч аэродромын зааварт тухайн нэмэлт өөрчлөлтийг оруулна.

139.129 Аюулгүй ажиллагааны үзлэг шалгалт ба аудит

[Хүчингүй болсон]

139.131 Нисэхийн судалгаа

(a) Гэрчилгээ эзэмшигч өөрийн үйл ажиллагаанд мониторинг хийж, аливаа ихээхэн өөрчлөлт орсон, эсхүл ихээхэн өөрчлөлт нь аэродромын аюулгүй ажиллагаанд нөлөө үзүүлж магадгүй нөхцөлд нисэхийн судалгаа хийнэ.

(b) Энэ зүйлийн (a) –д заасан томоохон өөрчлөлт гэдэгт доорхи зүйлүүд багтана.

(1) аэродром дахь агаарын хөдөлгөөний хэмжээ эрс нэмэгдсэн, эсхүл

(2) ашиглаж буй агаарын хөлгийн маягт томоохон өөрчлөлт орсон, эсхүл

(3) аэродромын бодит үзүүлэлтүүдэд томоохон өөрчлөлт орсон, эсхүл

(4) ослын тоо нэмэгдсэн, эсхүл аэродромын орчимд эсхүл аэродром дээр зөрчлийн тоо нэмэгдсэн, эсхүл

(5) жилийн хөдөлгөөний тоо үргэлжилсэн 3 жилийн дотор ихэссэн

(i) 40,000 болон түүнээс илүү ИХНДбаХНДхөдөлгөөн; эсхүл

(ii) 7,500 ХНДхөдөлгөөн; эсхүл

(iii) 60,000, эсхүл ИХНДбаХНДхөдөлгөөнийг нийлүүлээд тооцсон, үүнээс

9,000, эсхүл түүнээс олон ХНДхөдөлгөөн бүртгэгдсэн, эсхүл

(iv) 15,000, эсхүл түүнээс олон ХНДхөдөлгөөн; эсхүл

(v) 100,000, эсхүл ИХНДбаХНДхөдөлгөөнийг нийлүүлээд тооцсон

(c) Гэрчилгээ эзэмшигч нисэхийн судалгаа хийлгэж дууссаны дараа нэн даруй:

1) Тухайн аэродромын үйл ажиллагааг эргэн харж, нисэхийн аюулгүй ажиллагааны эрх ашгийн дагуу аливаа шаардлагатай өөрчлөлтийг явуулж,

аэродромын зааварт нэмэлт өөрчлөлт оруулах журмын дагуу баримт бичигт нэмэлт өөрчлөлтийг оруулна.

(2) Нисэхийн судалгааны үр дүнг Даргад ирүүлнэ.

(d) Хэрэв боломжтой бол, гэрчилгээ эзэмшигч ихээхэн хэмжээний өөрчлөлт орохоос өмнө нисэхийн судалгааг явуулна.

(e) Хэрэв гэрчилгээ эзэмшигч ихээхэн хэмжээний өөрчлөлт орохоос өмнө нисэхийн судалгааг явуулах боломжгүй бол, өөрчлөлт орсны дараа аль болох түргэн хугацаанд нисэхийн судалгааг явуулна.

Г Бүлэг— Аэродромын аюулгүй байдал

139.201 Үйлчлэх хүрээ

[Хүчингүй болсон]

139.203 Аэродромын аюулгүй байдалд тавигдах шаардлагууд

Хашаа хаалтанд тавигдах шаардлагууд

(a) Аюулгүй байдлын үйлчилгээ бүхий аэродромын гэрчилгээ эзэмшигч энэ дүрмийн 139.69 - р зүйлийн / Олон нийтийн хамгаалалт/ шаардлагуудыг хэрэгжүүлэхээс гадна тухайн аэродромын хамгаалагдсан аливаа бүс эсхүл аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн бүсэд зөвшөөрөлгүй санамсаргүй нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, зөвшөөрөлгүй санаатайгаар нэвтрэх үйлдлийг зогсоох харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулна.

(b) Энэхүү зүйлийн (a) хэсэгт заасан хамгаалалт нь —

(1) олон нийтийн ба хамгаалагдсан бүсийн хооронд, эсхүл олон нийтийн болон аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн бүсийн хооронд тохирох цоожны систем эсхүл хяналтын систем бүхий хашаа, хаалга, гарц, ба бусад хаалт зэргээс бүрдэнэ.

(2) аливаа хамгаалагдсан бүс, эсхүл нэмэлт хамгаалагдсан бүс рүү холбогдсон аливаа хоолой, эсхүл аливаа суваг, ус зайлуулах системийн хяналтыг бататгасан байна.

(c) хамгаалагдсан бүс, нэмэлт хамгаалагдсан бүс рүү нэвтрэхээс хамгаалж, үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай ба орчин тойрны газар нутгийн байршлыг тооцож, энэ зүйлийн (b)(1) хэсэгт шаардсан хаалт, хашааны өндрийг 2440 мм —ээс намгүй өндөртэй байхаар барина.

Бусад шаардлагууд

(d) Аюулгүй байдлын хамгаалалт бүхий аэродромын гэрчилгээ эзэмшигч нь —

- (1) хөндлөнгийн хууль бус үйлдлийн объект болж болзошгүй эсвэл болсон эсхүл өөр аюулгүй байдлын шалтгаанаарааэродромын ердийн үйл ажиллагаанаас тусгаарлах шаардлагатай агаарын хөлгийг зогсоох тусгаарлагдсан агаарын хөлгийн зогсоолын байршлыг тогтооно.
- (2) 30эсхүл түүнээс дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудалтай онгоцоор шөнийн цагаарзорчигч тээврийн зориулалтаар агаарын тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй аэродромын зогсоолын аль ч бүсэд гэрэлтүүлгээр хангах, ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах ба гэрэлтүүлгийн ердийн систем гэмтсэн үед онцгой байдлын гэрэлтүүлгээр ханган засвар үйлчилгээг хариуцна.
- (3) Шөнийн нислэгтэй аэродромд тогтоосон аливаа тусгаарлагдсан агаарын хөлгийн зогсоолын бүсийг гэрэлтүүлгээр хангах эсхүл 30 минут асахзөөврийн гэрэлтүүлэгтэй байна.
- (4) Зорчигч, нисгэх баг, тээшинд үзлэг хийх зорилгоор аэродромд дараах бүсүүдийг тогтооно:
 - (i) агаарын хөлөгт суухаас өмнө олон улсын нислэгийн зорчигч, нисгэх баг, тээшинд аюулгүй байдлын үзлэг хийх бүс:
 - (ii) Үзлэгээр орсон олон улсын нислэгийн зорчигч, нисгэх багийг хориотой эд зүйлс эсхүл үзлэгээр ороогүй хүмүүстэй холбогдохоос сэргийлсэн үзлэгийн дараах бүс:
 - (iii) Олон улсын нислэгийн агаарын хөлгөөс буух явцад нислэгээр ирж буй, дамжин зорчих, онгоц дамжин солих зорчигчдыг аюулгүй байдлын үзлэгт хамрагдсан аливаа этгээдтэй харьцахаас сэргийлж ирж буй зорчигч, нисэх багийг явах зорчигч, нисэх багийн гишүүдээс тусад нь байршуулах бүсүүд:
- (4A) **Сайд, эсвэл** Дарга шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн бүс рүү нэвтрэх буй болон уг бүсэд байгаа хүн, эд зүйлс, бодис, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх болон эрэн хайх бүсүүдийг тогтооно.
- (5) **Сайд, эсвэл** Дарга шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлын заналхийлэлд хариу өгөх аливаа тохиолдолд энэ зүйлийн (d)(4) дэх хэсэгт заасан (олон улсын нислэгийн зорчигч, нисэх баг, тэдгээрийн тээшинд үзлэг хийх) орон нутгийн/дотоодын нислэгийн зорчигч, нисэх баг, тэдгээрийн тээшинд үзлэг хийх зорилгоор тодорхой бүсүүдийг аэродромд бэлтгэнэ.
- (6) үзлэгээр орсон зорчигчдын нэвтрэх бүсэд байрлах тухайн аэродром дээрх зөвшөөрөгдсөн бүсүүдийг үзлэгт хамрагдсан зорчигчдод дараах эд зүйлсийг дамжуулахаас сэргийлэх нэвтрэх хяналтын хангалттай арга хэмжээнүүдээр хангасан байдлаар/хэлбэрээр/маягаар зохион байгуулна.
 - (i) аливаа галт зэвсэг; эсвэл

- (ii) аливаа аюултай эсвэл довтолгооны зэвсэг эсхүл бүх төрлийн багаж хэрэгсэл; эсвэл
 - (iii) бүх төрлийн сум; эсвэл
 - (iv) Аливаатэсрэх бодис эсхүл төхөөрөмж эсхүл аливаа агаарын хөлөг дэх хүний амь эсхүл агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд аюул учруулахад ашиглаж болох аливаа хөнөөлт бодис эсхүл төхөөрөмж
- (7) энэхүү зүйлийн (d)(4), (d)(4A), (d)(5)-д тус тус заасан бүсүүдийг зөвшөөрөлгүй этгээд тухайн бүсэд нэвтрэхээс сэргийлсэн нэвтрэх хяналтын хангалттай арга хэмжээгээр хангасан байдлаар зохион байгуулна.
- (8) тухайн гэрчилгээ эзэмшигчийн ажил олгосон, ажилд орох мөн гэрээгээр ажил үүрэг гүйцэтгэх хүн бүрийг тухайн ажил үүрэгт нь хамааралтай аюулгүй байдлын зохих төвшний мэдлэгийг олгуулах аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр болон журамтай байна;
- (9) гэрчилгээ эзэмшигчийн аюулгүй байдлын аливаа журам, тухайн аэродромын аюулгүй байдалтай холбоотой тушаал шийдвэрийг зөрчсөн зөрчил, дутагдлыг тодорхойлж Даргад мэдээлэх журамтай байна;
- (10) цахилгаан хангамж, холбоо, цэвэр бохир усны хангамж зэрэг үйлчилгээнүүдийг нисэхийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглах эрсдлийг бууруулахын тулд болон тэдгээрээр хязгаарлагдахгүйгээр үйлчилгээнүүдийн аюулгүй байдлыг хангана;
- (11) Даргын шаардсан нөхцөлд аюулгүй байдлын бүсийн периметрт эсхүл тухайн аэродром доторх аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн бүсүүдэд тэмдгүүд байрлуулна;
- (12) доорхи зүйлийг баталгаажуулахын тулд дараах журмуудыг боловсруулсан байна.
- (i) зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслийг аюулгүй байдлын бүс рүү эсхүл аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн бүс рүү оруулахгүй байх;
 - (ii) аюулгүй байдлын бүс дотор эсхүл аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн бүс дотор илрүүлсэн зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл, сэжиг бүхий тээврийн хэрэгслийг зохих журмын дагуушийдвэрлэх;
- (e) Энэ зүйлийн (d)(8)–д заасан сургалтын хөтөлбөр нь дараах зүйлийг агуулна.
- (1) Анхан шатны сургалтын болон давтан сургалтын хамаарах хэсгүүдийг;
 - (2) Зохион байгуулсан сургалтын агуулгад нийцсэн мэдлэгийн сорил эсхүл ур чадварын үнэлгээ.
- (f) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (e)(i)–д заагдсан сургалтын хэсэг / сургалтбүрийг—

(1) Даргаар зөвшөөрөгдөхүйц сургалтын төлөвлөгөөтэй явуулж

(2) Тухайн гэрчилгээ эзэмшигчээс эрх олгогдсон этгээд системтэй, харилцан хамаарал бүхий аргачлалаар зохион байгуулахыг бататгана.

(g) гэрчилгээ эзэмшигч (d)(8) хэсгийн шаардлагын дагуу сургалтанд хамрагдах шаардлагатай ажилтан бүр 3 жилээс ихгүй хугацааны дотор сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын хэсэгт хамрагдахыг бататгасан байна.

(h) [Хүчингүй болсон]

(i) [Хүчингүй болсон]

139.205 Аюулгүй байдлын хамгаалалтгүй аэродромд тавигдах шаардлагууд

(a) Аюулгүй байдлын шаардлагагүй аэродромын гэрчилгээ эзэмшигч уг дүрмийн 139.69 –д заасан шаардлагыг биелүүлэхээс гадна доорхи ажлыг хийнэ.

(1) Аэродром дахь аюулгүй байдлын заналхийллийн эсрэг Сайд, эсхүл Дарга шаардсан нөхцөлд уг дүрмийн 139.203(d)(4A) ба 139.203(d)(4) –д шаардсан аюулгүй байдлын харуул хамгаалалттай аэродромын гэрчилгээ эзэмшигчээр аэродромын тухайн бүсийг хангах талаар нөөц төлөвлөгөөтэй байна.

(2) Энэ дүрмийн 139.203(d)(2), (3) ба (9) –р зүйлийн заалтыг аюулгүй байдлын хамгаалалттай аэродромын гэрчилгээ эзэмшигчийн нэгэн адил мөрдөж ажиллана.

(b) 19 эсхүл түүнээс дээш зорчигчийн суудалтай, маягийн гэрчилгээ бүхий зорчигч тээврийн зориулалтын агаарын тээврийн тогтмол нислэгийн онгоцонд үйлчлэх аюулгүй байдлын бус аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь -

(1) нийт ажилтнуудын аюулгүй байдлын ойлголт, мэдээллийг хангах, бусад байгууллагад хангалттай мэдээлэл өгөхийг бататгах зорилгоор аюулгүй байдлын ойлголт, мэдээллийн хэсгийг зохион байгуулсан байна.

(2) 12 сараас хэтрэхгүй хугацааны давтамжтай 1 хэсэгт заасан аюулгүй байдлын хэсгийн хурал, зарлан хуралдуулж, даргалж, протокол хөтлөсөн байна.

(c) гэрчилгээжсэн суудлын багтаамж 19 эсхүл түүнээс дээш тоотой онгоцоор тогтмол зорчигч тээврийн үйл ажиллагаа явуулж буй харуул хамгаалалтгүй аэродромын гэрчилгээ эзэмшигчийн хөлслөн эсхүл гэрээгээр ажиллуулж буй ажилтан бүр тухайн ажилтны үүрэгт тохирсон аюулгүй байдлын нөхцлийн холбогдох түвшний ухамсартай байхыг бататгахын тулд аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны журамтай байна.

(d) (c) хэсэгт шаардсан сургалтын хөтөлбөр доорхи зүйлийг агуулсан байна.

(1) Анхан шатны болон давтан сургалтын холбогдох хэсгүүд

- (2) мэдлэг шалгах тест эсхүл хийгдсэн сургалтын үр дүн, чадварын шалгалт
- (е) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (d)(1)–д заагдсан сургалтын хэсэг / сургалт бүрийг —
- (1) Дарга хүлээн зөвшөөрөхүйц сургалтын төлөвлөгөөг багтаасан
- (2) гэрчилгээ эзэмшигчийн зөвшөөрсөн этгээдээр зохицуулагдаж, зохион байгуулагдаж явагдсан
- (f) гэрчилгээ эзэмшигч сургалтанд хамрагдах шаардлагатай ажилтан бүр 3 жилээс ихгүй хугацааны дотор сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын хэсэгт хамрагдахыг бататгасан байна.
- (g) [Хүчингүй болсон]

Д Бүлэг– Нөөц

Е Бүлэг– UNICOM / нийтлэг холбоо /ба AWIB / аэродромын цаг уурын мэдээлэл дамжуулагч /үйлчилгээнүүд

139.351 UNICOM ба AWIB үйлчилгээнүүдийн хангалт

- (a) Аливаа этгээд :
- (1) Энэ дүрмийн шаардлагын дагуу үйл ажиллагаа, хангалтыг явуулаагүй бол UNICOM үйлчилгээ эрхлэхийг хориглоно.
- (2) Энэ дэд бүлгийн дагуу UNICOM ба AWIB үйлчилгээнүүдийн үйл ажиллагаа, хангалтыг явуулахаас өөрөөр, нисэхийн үйл ажиллагааг дэмжих үүднээс нислэгийн хөдөлгөөний үйлчилгээтэй холбоогүй аэродромын мэдээлэл эсхүл цаг агаарын мэдээг дамжуулах, мэдээлэхийг хориглоно.
- (b) Энэ бүлэг нь ИНД-174.6–д заасны дагуу цаг агаарын суурь мэдээг мэдээлэхэд аливаа этгээдэд саад болохгүй.
- (c) Аливаа аэродром нэгэн зэрэг нэгээс илүү UNICOM үйлчилгээ эсхүл нэгээс илүү AWIB үйлчилгээ ажиллуулахыг хориглоно.

139.353 UNICOM ба AWIB үйлчилгээний шаардлагууд

(a) UNICOM эсхүл AWIB үйлчилгээ эрхлэхээр төлөвлөж буй этгээд:

- (1) ИНД 171.17 –р зүйлд шаардсан дуудлага нэр авахаар Даргад өргөдөл гаргана.
- (2) Харилцаа холбооны тухай хуулийн дагуу олгогдох радио төхөөрөмжийн холбооны давтамжийн зөвшөөрөл хүсч өргөдөл гаргана.
- (3) үйлчилгээ явуулахаар төлөвлөж буй газрын аэродромын үйл ажиллагаа эрхлэгчөөс бичгээр ирүүлсэн зөвшөөрөл авна.

(b) UNICOM эсхүл AWIB үйлчилгээг хангаж эсхүл үйлчилгээ үзүүлж буй этгээдуг UNICOM эсхүл AWIB үйлчилгээний үйл ажиллагаа явагдаж буйг бататган:

- (1) Энэ зүйлийн (a) (1)-д заасан дуудлага хуваарилагдсан
- (2) Энэ зүйлийн (a) (2) –д заасан харилцаа холбооны давтамжийн эрхийн дагуу
- (3) ИКАО Аннекс Хавсралт 10, Боть III, Бүлэг II Хэсэг 2 –д тайлбарласан хамаарах системийн үзүүлэлттэй тохирсон
- (4) ИКАО Аннекс Хавсралт 10, Боть II–т тайлбарласан хамаарах холбооны үйл ажиллагааны журмын дагуу

(c) UNICOM эсхүл AWIB үйлчилгээг хангаж эсхүл үйлчилгээ үзүүлж буй этгээдуг UNICOM эсхүл AWIB үйлчилгээний доорхи үйл ажиллагааг явуулахгүй байхыг бататгасан байна.

- (1) буруу эсхүл алдаатай мэдээлэл дамжуулах, эсхүл
- (2) мэдээ дамжуулах үед хүлээн авсан мэдээллийг өөрчлөх, эсхүл
- (3) аливаа нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эсхүл цаг уурын үйлчилгээтэй зөрчилдөх

(d) UNICOM эсхүл AWIB үйлчилгээг хангаж эсхүл үйлчилгээ үзүүлж буй этгээдуг UNICOM эсхүл AWIB үйлчилгээний үйл ажиллагаа явагдаж буйг бататган

- (1) Алдаатай эсхүл буруу мэдээлэл дамжуулаагүйг
- (2) хэрэв үйл ажиллагаа эрхлэгч эсхүл үйлчилгээ үзүүлэгч алдаатай мэдээлэл дамжуулснийг сэжиглэх аливаа шалтгаан байвал үйлчилгээг үргэлжлүүлэхийг зөвшөөрөхгүй байх
- (3) ИНД 174.6 –н дагуу цаг агаарын суурь мэдээ дамжуулах шаардлагад нийцэж байгааг

(e) UNICOM үйлчилгээ явуулж буй эсхүл хангалт үзүүлж буй этгээд

- (1) ИНД 174.6–н дагуу цаг агаарын суурь мэдээгээр хангаж байгааг, эсхүл иргэний нисэхийн тухай хууль болон ИНД 174.6 –н дагуу Даргын олгосон цаг агаарын үйлчилгээ үзүүлэх гэрчилгээний хүрээнд цаг агаарын мэдээгээр хангаж байгааг
 - (2) цаг уурын суурь мэдээний үзүүлсэн эсхүл бусад холбоотой цаг уурын мэдээллийн аль нэгээс болон тухайн аэродромыг ашиглаж буй агаарын хөлгийн нисгэгчээс ирүүлсэн ашиглаж буй ХБЗ-ны салхины чиглэлийн мэдээллээр хангаж байгааг
 - (3) ИНД – 119.73 –р зүйлийн дагуу агаарын тээвэрлэгчид тавигдах шаардлагын дагуу нислэгийн дараахи яриа явуулж байгааг
 - (4) онцгой байдлын үед хариу үзүүлж эхлэх
 - (5) Аэродромын давтамжид хариу үзүүлэх нэгжтэй байх
 - (6) Нисгэгчийн хүсэлтээр, UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч мэдэгдэж буй аливаа агаарын хөлгийн байршлын талаар мэдээллээр хангаж байгааг
 - (7) НМУ–ээр зарлан мэдээлсэн эсхүл нийтлэгдсэн аэродромын талаархи агаарын навигацитай холбоотой түр эсхүл байнгын аюулын мэдээг дамжуулах
- (f) UNICOM үйлчилгээ явуулж буй эсхүл хангалт үзүүлж буй этгээд
- (1) Аливаа Нислэгийн Хөдөлгөөний Үйлчилгээ үзүүлэхгүй байх, эсхүл
 - (2) хөдөлгөөний мэдээллийг өгөх эсхүл санал болгох, эсхүл
 - (3) хөдөлгөөний мэдээллийн санал гаргах эсхүл орлуулах
- (g) Энэ бүлгийн дагуу UNICOM үйлчилгээ үзүүлж буй этгээд UNICOM байгууламж ажиллуулж буй ажилтнуудад эрх өгөх, ур чадварыг үнэлэх сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.
- (h) AWIB үйлчилгээ үзүүлж буй эсхүл хангаж буй этгээд дор дурдсан мэдээллээр хангаж болно.

- (1) салхины чиглэл ба хүч:
- (2) хараа / алсын барааны харагдац:
- (3) үүлний бүрхэлт:
- (4) агаарын температур:
- (5) далайн түвшний агаарын даралт, эсхүл иргэний нисэхийн хууль болон ИНД 174-ын дагуу Даргын олгосон цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээний дагуу QNH

- (6) ИНД 174.6 –р зүйлийн дагуу цаг уурын суурь мэдээний хангалт үзүүлсэн эсхүл бусад холбоотой цаг уурын мэдээллийн аль нэгээс болон тухайн аэродромыг ашиглаж буй агаарын хөлгийн нисгэгчээс ирүүлсэн ашиглаж буй ХБЗ-ны салхины чиглэлийн мэдээллээр хангаж байгааг
- (7) тухайн аэродромыг ашиглаж буй агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой хөдөлгөөний мэдээллээс бусад үйл ажиллагаа

139.355 UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчт тавигдах шаардлага

UNICOM үйлчилгээ ажиллуулж буй этгээд нь :

- (1) хувийн нисгэгчийн үнэмлэхний эсхүл түүнтэй ижил хэмжээний нислэгийн радио холбооны шаардлага хангана гэж тэнцсэн, сургалтанд хамрагдсан байх
- (2) үзүүлж буй үйлчилгээний шаардлагад нийцэжтэнцсэн, сургалтанд хамрагдсан
- (3) үйлчилгээ үзүүлэх ажлын зөвшөөрөл бичгээр нотлогдсон байх

139.357 UNICOM эсхүл AWIB үйлчилгээний мэдээллийг зарлах

UNICOM эсхүл AWIB үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж буй этгээд хамгийн багадаа тухайн үйлчилгээг эхлүүлэхээс 90 хоногийн өмнө Монгол Улсын НМЭ –д зарлан нийтлүүлэхээр НМУ үзүүлэгч байгуулагад доорхи мэдээллийг хүргүүлсэн байна.

- (1) үйлчилгээний байршил, дуудлага, радио долгионы давтамж
- (2) үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж буй аэродромын тодорхойлолт, эсхүл аэродромуудын тодорхойлолтууд
- (3) үйл ажиллагаа явуулах цаг
- (4) Үйлчилгээний талаархи нарийвчилсан мэдээлэл
- (5) Үйл ажиллагаатай холбоотой бусад аливаа мэдээлэл
- (6) Захиргааны нарийвчилсан мэдээллүүд, Үүнд:
 - (i) Үйлчилгээ үзүүлэгчийн нэр, шуудангийн хаяг, хэрэв байвал электрон шуудан, утасны дугаар, факсын дугаар

- (ii) НМЭ-д зарлагдсан мэдээллийн өөрчлөлт, НОТАМ мэдээ дамжуулах, хүлээн авах хариуцсан хүний нэр, утасны дугаар, шуудангийн хаяг, хэрэв байвал электрон шуудан, утасны дугаар, факсын дугаар

139.359 Одоо байгаа үйлчилгээнээс шилжих зохицуулалт

[Хүчингүй болсон]

Ж Бүлэг–Хязгаарлагдмалаэродромын үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх шаардлагууд

139.401 Ажилтнуудад тавигдах шаардлагууд

(а) Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь дор дурдсан ажилтнуудыг авч ажиллуулсан, эсхүл контрактаар гэрээлсэн байна.

(1) ерөнхий захирлаар нэр дэвшсэн удирдах албан тушаалтан нь:

- (i) Өргөдөл гаргагч байгууллагын бүх үйл ажиллагаа нь энэ дүрмийн стандарт, шаардлагыг биелүүлэн дүрмийн шаардлагын хүрээнд явагдаж, санхүүжиж байгааг бататгаж, эрх мэдэл бүхий байна.
- (ii) Энэ дүрмийн стандарт шаардлагыг өргөдөл гаргагч байгууллага биелүүлж байгааг бататган, хариуцлага хүлээсэн байна.

(2) Нисэх буудлын менежерээр томилогдсон удирдах албан тушаалтан эсхүл удирдах албан тушаалтнууд нь:

- (i) аэродромын байгууламж ба түүний үйл ажиллагаа энэ дүрмийн А, G, Нбүлгийн шаардлагатай нийцэж байгааг бататган, хариуцлага хүлээсэн байна.
- (ia) Энэ дүрмийн 139.409–р зүйлд шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны хариуцлагыг хүлээсэн байна.

(ii) Хэрэв удирдах албан тушаалтан нь ерөнхий захирлаас өөр ажилтан бол ерөнхий захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээнэ.

(3) тухайн аэродромын байгууламж, үйл ажиллагааг явуулах болон түүний үйлчилгээ, байгууламж нь Энэ дүрмийн бүлэг А, G, Н–д заагдсан стандарт шаардлагыг биелүүлэх чадвартай хангалттай тооны ажилтнуудтай байна.

(аа) Энэ зүйлийн (а)(2)(ia) -д заасан удирдах албан тушаалтан гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй ажиллагааны системийн удирдлагатай холбоотой мэдлэг, ур чадвар, туршлагаа нотлох боломжтой байна.

(b) Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь тухайн аэродром, түүний үйлчилгээ, байгууламжийг ашиглах, арчлах, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай ажилтнуудын мэргэшлийн ур чадварыг эхлэн тогтоох, үнэлэх, үргэлжлүүлэн хадгалах журамтай байна.

Тодорхойгүй байдал үүсгэхгүйн тулд, энэ зүйлийн (а)(2) –р зүйлд заасан удирдах албан тушаалтан болон ерөнхий захирлын ажлыг нэг хүн гүйцэтгэж болно.

139.403 Аэродромын хязгаарлалтууд

Аэродромынхязгаарлагдмал гэрчилгээ эзэмшихөргөдөл гаргагч нь тухайн аэродромын төлөвлөлт, эсхүл байгууламж, эсхүл үзүүлж буй үйлчилгээнээс шалтгаалж, агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бол аэродром ашиглах тохирох хязгаарлалтыг тогтоосон байна.

139.405 Хамгаалалтын арга хэмжээ

Аэродромын хязгаарлагдмалгэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь тухайн аэродром дээр доорхи шаардлагуудыг хангасан байна.

- (1) аэродромын хөдөлгөөнд саад болох мал, амьтан нэвтрэн орохоос хамгаалсан байна.
- (1A) Зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгсэл аэродромын үйл ажиллагаа явуулдаг бүс рүү нэвтрэн орохоос хамгаалсан байна.
- (2) Онгоцны хөдөлгүүрийн үлээлтэд хүн, өмч хөрөнгө өртөхөөс хамгаалах боломжтой байна.

139.407 Аэродромын өгөгдөл ба мэдээллийг зарлан мэдээлэх

Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад мэдээлэл өгөх үйл ажиллагааг журмаар зохицуулсан байна.

- (1) Аэродромын өгөгдөл ба мэдээлэл

- (2) Энэ дүрмийн 139. 53 –д заасны дагуу аэродромыг ашиглах талаар тогтоосон аливаа хязгаарлалт
- (3) Аэродромыг ашиглахад нөлөөлөх аливаа өөрчлөлт гарвал, аль болох түргэн хугацаанд

139.409 Аюулгүй ажиллагааны удирдлага

Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч ИНД -100.3 дүрмийн дагуу тухайн аэродромд аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог тогтоож, хэрэгжүүлж, үргэлжлэн хадгална.

139.411 Хөдөлгөөний өгөгдлийг мэдээлэх

Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмших өргөдөл гаргагч тухайн аэродромын сарын нислэгийн хөдөлгөөний өгөгдлийг цуглуулж, Даргад 3 сар тутам уг мэдээг ирүүлнэ.

139.413 Аэродромд ажил хийгдэх

Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмших өргөдөл гаргагчнь тухайн аэродромд хийгдэх болон хийгдэж байгаа аливаа ажил нь агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюул, эрсдэл учруулахгүй байх, аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ бүхий журамтай байна.

139.415 Баримт бичгийн хяналт

Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч:

- (1) Аэродромын байгууламж, үйлчилгээ ба үйл ажиллагаа, хангалтыг явуулахад зайлшгүй холбоотой баримт бичгийн хувийг байлгана.
- (2) Энэ зүйлийн (1) –д шаардсан баримт бичгийн хяналтын журамтай байна.
 - (i) Баримт бичиг ашиглах шаардлагатай ажилтнуудын ажлын байр бүрд холбогдох бичиг баримтын хүчин төгөлдөр хувийг байлгана.
 - (ii) Хуучирсан, хүчингүй баримт бичгийг гаргасан газар нь түргэн устгасан байна.

- (iii) Хүчин төгөлдөр бус, хуучирсан материал ашиглахаас сэргийлж баримт бичгийн хүчинтэй хувилбарыг тодорхойлох боломжтой байлгахыг бататгасан байна.

139.417 Аэродромын хязгаарлагдмалгэрчилгээ эзэмшигчийн аэродромын заавар

(a) аэродромынхязгаарлагдмалгэрчилгээ эзмшихээр өргөдөл гаргагч Даргад доорхи зүйлийг агуулсан аэродромын зааврыг ирүүлнэ.

- (1) Өргөдөл гаргагч байгууллагын нэрийн өмнөөс ерөнхий захирлын гарын үсэг, батламж бүхий аэродромын заавар, журам нь
 - (i) Энэ дүрмийн шаардлагад нийцсэнийг баталсан бүтэц, зохион байгуулалтыг тогтоосон ба аргачлал, арга хэрэгслийг үзүүлсэн
 - (ii) үйл ажиллагаанд байнга мөрдөж ажиллахаа нотолсон
- (1A) Энэ дүрмийн 139.409 –р зүйлд шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоотой холбоотой
 - (ii) ИНД - 100.3(b) –д шаардсан бүх бичиг баримт
 - (iii) Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ дахин олгохоос бусад өргөдөл гаргагч ААУТ –г хэрхэн хэрэгжүүлэх талаар тайлбарласан хэрэгжүүлэх төлөвлөгөө
- (2) Энэ дүрмийн 139.401(a)(1) and 139.401(a)(2) зүйлд шаардсаны дагуу удирдах албан тушаалтан, эсхүл албан тушаалтнуудын нэр, албан тушаал
- (3) Удирдах албан тушаалтан, эсхүл албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагыг Энэ дүрмийн 139.401(a)(1) and 139.401(a)(2) зүйлд шаардсаны дагуу
 - (i) хүлээсэн хариуцлагын дагуу байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах талаар
 - (ii) аюулгүй ажиллагааны удирдлагын талаархи үүрэг хариуцлага
- (4) хэрэв хамааралтай бол, энэ дүрмийн 139.401(a)(1) ба (2)-т шаардсаны дагуу удирдах ажилтнууд, эсхүл удирдах ажилтны хариуцлагын шугамыг харуулсан байгууллагын бүтэц, зохион байгуулалтын зураг
- (5) энэ дүрмийн 139.403–р зүйлд тогтоосон тухайн аэродромыг ашиглах талаархи аливаа хязгаарлалт

(6) энэ дүрмийн139.405-р зүйлд шаардсан олон нийтийг хамгаалах ажлын талаархи танилцуулга

(6А) байгууллага доторхи аюулгүй ажиллагааны хариуцлагын шугамыг тодруулсан мэдээлэл

(7) Дүрмийн 139.407–т шаардсан аэродромын өгөгдөл болон мэдээллийг зарлан мэдээлэх журам

энэ дүрмийн Бүлэг А Б В эсхүл Г –ийн аливаа шаардлагуудаас өргөдөл гаргагчийг чөлөөлөх хүчин төгөлдөр чөлөөлөлт бүр

(8) Хүчингүй болсон

(9) Дүрмийн 139.411 -р зүйлд шаардсан нислэгийн хөдөлгөөний өгөгдлийг цуглуулах, түүнийг мэдээлэх үйл ажиллагааны журам

(10) Дүрмийн 139.413 –д шаардсан аэродром дахь аливаа ажил хийгдэх үеийн анхааруулга санамж, журам

(11) Дүрмийн 139.415(2) -д шаардсанаэродромын хангалт, үйл ажиллагаа явуулахад шаардагдах бичиг баримтын хяналт, зохицуулалтын журам

(12) Аэродромын зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах, тараах журам

(b) Аэродромын зааварт энэ зүйлийн а-д хэсэгт зааснаас гадна дүрмийн 139.21-р зүйлд шаардсан нисэхийн судалгаагаар тогтоосон доорхи зүйлийн аль нэгэнд хамаарах эрсдлийг удирдахад зайлшгүй үйл ажиллагаа эсхүл шаардлагуудыг оруулсан байна.

(1) бодит үзүүлэлт, саадыг хязгаарлах гадаргуу, ил харааны тоноглол, тоног суурилгасан тоног төхөөрөмж, төгсгөлийн аюулгүй зурвас

(2) аэродромын онцгой байдлын төлөвлөгөө

(3) Авран хамгаалах гал унтраах

(4) Мал, амьтан, шувуутай тэмцэх

(5) Аэродромын ашиглалт арчлалт

(6) Навигацийн ил харааны тоноглол- арчлалт, хяналт

(7) Аэродромын нислэг хөдөлгөөний үйлчилгээ

(8) Перроны удирдлага зохицуулалтын үйлчилгээ

(9) Аэродромд үзлэг хийх хөтөлбөр

(10) Газрын үйлчилгээний машин

(11) НХҮ ба навигацийн тоноглолыг хамгаалах

(12) Аэродромын байдлыг зарлан мэдээлэх

(с) Дүрмийн 139.21 эсхүл 139.457 –р зүйлээр шаардсан нисэхийн судалгаагаар тогтоосон эрсдлийг удирдах эсхүл бууруулах зорилгоор энэ Бүлэгт шаардсан зааврыг Бүлэг Б ба В –н шаардлагаар орлуулан хэрэглэж болно.

(d) Аэродромын заавар Даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

3 Бүлэг —Хязгаарлагдмал гэрчилгээтэй аэродромд тавигдах үйл ажиллагааны шаардлагууд

139.451 Үргэлжлэн мөрдөж ажиллах

хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигч—

- (1) Энэ дүрмийн 139.417 –р зүйлд шаардсан аэродромын хүчин төгөлдөр зааврын нэг хувийг тухайн аэродром дээр байлгана.
- (2) Аэродромын зааварт заасан хөтөлбөр, систем, үйл ажиллагааны бүх журмыг биелүүлнэ.
- (3) Тухайн ажилтуудын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аэродромын зааврын хамаарах хэсгийг ажилтнуудад хүртээмжтэй байлгана.
- (4) Энэ дүрмийн БүлэгЖ–т тогтоосон шаардлагыг биелүүлж, стандартад нийцүүлэн ажиллана.
- (5) ИНЕГ -24139/01 маягтаар шаардсан үйлчилгээний хаяг, утасны дугаар эсхүл бусад харилцах мэдээлэлд аливаа өөрчлөлт орсон нөхцөлд Даргад 28 хоногийн дотор мэдэгдэнэ.

139.453 Аюултай нөхцлүүд

Аэродромын хязгаарлагдмалгэрчилгээ эзэмшигч тухайн аэродромын аль нэг хэсэгт аюултай нөхцөл байдал үүссэн үед агаарын хөлгийн үйл ажиллагааг энэ хэсэгт хязгаарлах, эсхүл шаардлагатай тохиолдолд хориглох зохицуулалтыг бататгасан журамтай байна.

139.455 Гэрчилгээ эзэмшигчийн зохион байгуулалтанд өөрчлөлт хийгдэх

(a) Аэродромын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигч бүр тухайн аэродромын заавар нь агуулга болон холбоотой байгууламж, үйлчилгээ, үйл ажиллагаа, хөтөлбөр, төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлтийн дагуу тайлбарлагдаж хадгалагдаж байгааг бататгасан байна.

(b) Гэрчилгээ эзэмшигч аэродромын зааварт багтсан үйл ажиллагааны стандарт журмуудын аливаа нэмэлт өөрчлөлт бүр нь энэхүү дүрмийн холбогдох шаардлагатай бүрнээ нийцэж байгааг бататгасан байна.

с) Гэрчилгээ эзэмшигч нь аэродромын зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа нэмэлт өөрчлөлт бүрийн хувийг Даргад аль болох түргэн ирүүлсэн байна.

(d) Хэрэв гэрчилгээ эзэмшигч доорхи асуудлаар өөрчлөлт оруулахаар санал болгосон нөхцөлд Даргад урьдчилан мэдэгдэж хүлээн зөвшөөрүүлсэн байхыг шаардана.

(1) Гүйцэтгэх Ерөнхий Захирал

(2) Удирдах, ахлах ажилтнууд / жагсаалтад орсон /

(e) Дарга Энэ зүйлийн (d) тогтоосон өөрчлөлтийн үед эсхүл дараа нь гэрчилгээ эзэмшигч үйл ажиллагааг хэрхэн явуулах нөхцлийг тогтоож болно.

(f) Гэрчилгээ эзэмшигч нь Энэ зүйлийн (d) –д тогтоосон бүх нөхцлийг биелүүлэх үүрэгтэй.

(g) Хэрэв энэхүү дүрэмд хамаарах аливаа өөрчлөлт нь аэродромын гэрчилгээнд өөрчлөлт оруулахаар бол гэрчилгээ эзэмшигч Даргад аэродромын гэрчилгээг аль болох түргэн ирүүлнэ.

(h) Дарга аюулгүй ажиллагааны эрх ашгийн үүднээс шаардлагатай гэж үзвэл, гэрчилгээ эзэмшигч аэродромын зааварт тухайн нэмэлт өөрчлөлтийг оруулна.

139.457 Нисэхийн судалгаа

(a) Хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигч өөрийн үйл ажиллагаанд мониторинг хийж, аливаа ихээхэн өөрчлөлт орсон, эсхүл ихээхэн өөрчлөлт нь аэродромын аюулгүй ажиллагаанд нөлөө үзүүлж магадгүй нөхцөлд нисэхийн судалгаа хийнэ.

(b) Энэ зүйлийн (a) –д заасан томоохон өөрчлөлт гэдэгт доорхи зүйлүүд багтана.

(1) аэродром дахь агаарын хөдөлгөөний хэмжээ эрс нэмэгдсэн, эсхүл

(2) ашиглаж буй агаарын хөлгийн маягт томоохон өөрчлөлт орсон, эсхүл

(3) аэродромын бодит үзүүлэлтүүдэд томоохон өөрчлөлт орсон, эсхүл

(4) ослын тоо нэмэгдсэн, эсхүл аэродромын орчимд эсхүл аэродром дээрхи зөрчлийн тоо нэмэгдсэн, эсхүл

(5) жилийн хөдөлгөөний тоо үргэлжилсэн 3 жилийн дотор ихэссэн

- (i) 40,000 болон түүнээс илүү ИХНДбаХНД–р үйлдсэн хөдөлгөөн; эсхүл
 - (ii) 7,500 ХНДхөдөлгөөн; эсхүл
 - (iii) 60,000, эсхүлИХНДбаХНДхөдөлгөөнийг нийлүүлээдтооцсон, үүнээс 9,000, эсхүл түүнээс олон ХНДхөдөлгөөн бүртгэгдсэн, эсхүл
 - (iv) 15,000, эсхүлтүүнээс олон ХНДхөдөлгөөн; эсхүл
 - (v) 100,000, эсхүлИХНДбаХНДхөдөлгөөнийг нийлүүлэд тооцсон
- (c) Хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигч нисэхийн судалгаа хийлгэж дууссаны дараа нэн даруй:
- 1) Тухайн аэродромын үйл ажиллагааг эргэн харж, нисэхийн аюулгүй ажиллагааны эрх ашгийн дагуу аливаа шаардлагатай өөрчлөлтийг явуулж, аэродромын зааварт нэмэлт өөрчлөлт оруулах журмын дагуу баримт бичигт нэмэлт өөрчлөлтийг оруулна.
 - (2) Нисэхийн судалгааны үр дүнг Даргад ирүүлнэ.
- (d) Хэрэв боломжтой бол, хязгаарлагдмалгэрчилгээ эзэмшигч ихээхэн хэмжээний өөрчлөлт орохоос өмнө нисэхийн судалгааг явуулна.
- (e) Хэрэв хязгаарлагдмалгэрчилгээ эзэмшигч ихээхэн хэмжээний өөрчлөлт орохоос өмнө нисэхийн судалгааг явуулах боломжгүй бол , өөрчлөлт орсны дараа аль болох түргэн хугацаанд нисэхийн судалгааг явуулна.

И Бүлэг — Гэрчилгээжээгүй аэродромын үйл ажиллагааны шаардлагууд

139.501 Бүлгийн үйлчлэх хүрээ

- (a) Энэ бүлгийн b зүйлд зааснаас бусад тохиолдолд энэхүү бүлэг нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид хамаарна.
- (b) Энэ дэд хэсэг нь дор дурдсан аэродромд хамаарахгүй. Үүнд:
 - (1) Аэродромын гэрчилгээ эзэмшигч
 - (2) Хязгаарлагдмалаэродромын гэрчилгээ эзэмшигч:
 - (3) Зөвхөн газар тариалангийн зориулалтаар ашиглах, эсхүл ашиглахаар бэлтгэгдсэн аэродромын үйл ажиллагаа эрхлэгч

139.503 Аюултай нөхцлүүд

Энэ дэд бүлгийн шаардлага хамаарах аэродромын үйл ажиллагаа эрхлэгч тухайн аэродромын аль нэг хэсэгт аюултай нөхцөл байдал үүссэн үед агаарын хөлгийн хөдөлгөөнийг энэ хэсэгт хязгаарлах, эсхүл шаардлагатай тохиолдолд хориглох зохицуулалтыг бататгасан журамтай байна.

139.505 Хөдөлгөөний тоог мэдээлэх

Энэ бүлгийн шаардлагад хамаарах аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь:

- (a) Тухайн аэродромын агаарын хөдөлгөөний тоо, өгөгдлийн жилийн тайланг ИНЕГ-т ирүүлнэ.
- (b) Хэрэв Дарга бичгээр хүсэлт гаргасан нөхцөлд тухайн аэродромын хөдөлгөөний тоо, өгөгдлийг бүртгэж, мэдээлнэ.

К Бүлэг — Шилжих нөхцлүүд

139.551 Олон улсын тогтмол агаарын тээвэрт үйлчлэх аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч, өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны шилжилт

- (a) Энэхүү дүрэм нь доорхи нөхцөл бүрд хамаарна.
 - (1) агаарын тээврийн тогтмол үйл ажиллагаанд үйлчлэх аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч хэрвээ-
 - (i) тухайн агаарын хөлгийн хөөрөх цэг Монгол улсын гадна боловч Монгол улсад буух бол, эсхүл
 - (ii) тухайн агаарын хөлгийн буух цэг Монгол улсын гадна орших боловч, хөөрөх цэг Монгол улсад бол
 - (2) агаарын тээврийн тогтмол үйл ажиллагаанд зориулагдсан аливаа агаарын хөлөгт үйлчлэх аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч хэрвээ -
 - (i) тухайн агаарын хөлгийн хөөрөх цэг Монгол улсын гадна боловч Монгол улсад буух бол, эсхүл

- (ii) тухайн агаарын хөлгийн буух цэг Монгол улсын гадна орших боловч, хөөрөх цэг Монгол улсад бол
- (b) 2018 оны 2-р сарын 1 –ээс өмнө энэхүү дүрмийн шаардлага хамаарах байгууллага
- (1) дараах шаардлагыг биелүүлэх шаардлагагүй. Үүнд:
- (i) энэ дүрмийн 139.55(a)(2)(ii) зүйлийг, хэрэв аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хариуцсан удирдах албан тушаалтны оронд тухайн байгууллага дотоод чанарын хяналтын баталгаа хариуцсан удирдах ажилтантай бол:
- (ii) Энэ дүрмийн 139.75 –р зүйлийг, хэрэв аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог тогтоох, хэрэгжүүлэх, хадгалахын оронд байгууллага энэхүү дүрмийн 139.557 –р зүйлд шаардсан дотоод чанарын хяналтын системтогтоосон бол:
- (iii) Энэ дүрмийн 139.77(a)(1A)-р зүйлийг:
- (iv) Энэ дүрмийн 139.77(a)(3)(ii)-р зүйлийг:
- (v) Энэ дүрмийн 137.77(a)(6A)-р зүйлийг, гэхдээ:
- (2) 2016 оны 7-р сарын 30-ны дотор ИНЕГ-аас гаргасан маягыг бөглөж хавсарган, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Даргад ирүүлсэн байна.
- (i) ААУТ-г хэрэгжүүлэх төлөвлөсөн огноог багтаасан байна.
- (ii) Энэ дүрмийн 139.75-д шаардсан байгууллага аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхээртөлөвлөж буй талаар тайлбар
- (c) Дарга шаардлага хангасан гэж үзвэл -
- (1) байгууллагын ААУТ-г хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах болон
- (2) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноог тогтооно.
- (d) Тодорхой байх үүднээс аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноо нь Дарга зөвшөөрөл олгосон огноо байна.
- (e) Энэ дүрмийн 139.551(c)(2)-ын дагуу хэрэгжүүлэх өдрийг тогтоохдоо Дарга дараах зүйлсийг харгалзан үзнэ:
- (1) байгууллагын чадамж
- (2) байгууллагын бүтэц зохион байгууллалт
- (3) байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гардаг эрсдэлүүд
- (4) аливаа гэрчилгээний хугацаа сунгах огноо:
- (5) аливаа нөөц эсхүл байгууллагын ажлын хуваарийн хувьд байгууллага эсхүл эрх бүхий байгууллага эсхүл хоёуланд нь үзүүлж болох нөлөө:

(б) хэрэгжүүлэх хугацаа нь 2018 оны 2-р сарын 1-ээс хойшгүй байна.

(f) Хэрэв байгууллага нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч бол гэрчилгээ хүссэн өргөдлөө аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт ирүүлнэ.

Энэ дүрэм 2018 оны 2-р сарын 1-ны өдөр хүчингүй болно.

139.553 Олон улсын тогтмол агаарын тээвэрт үйлчлэхгүй аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч, өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны шилжилт

(a) Энэ дүрэм нь дараахи байгууллагад хамаарна.

(1) тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд зориулагдсан аливаа онгоцонд үйлчлэхгүй аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч хэрэв

(i) тухайн агаарын хөлгийн хөөрөх цэг Монгол улсын гадна боловч, Монгол улсад буух бол, эсхүл

(ii) тухайн агаарын хөлгийн буух цэг Монгол улсын гадна орших боловч, хөөрөх цэг Монгол улсад бол

(2) Тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд зориулагдсан аливаа онгоцонд үйлчлэхгүй аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч хэрэв-

(i) тухайн агаарын хөлгийн хөөрөх цэг Монгол улсын гадна боловч Монгол улсад буух бол, эсхүл

(ii) тухайн агаарын хөлгийн буух цэг Монгол улсын гадна орших боловч, хөөрөх цэг Монгол улсад бол

(b) 2021 оны 2-р сарын 1-ээс өмнө энэ дүрэм хамаарах байгууллага—

(1) дараах шаардлагыг биелүүлэх шаардлагагүй

(i) Энэ дүрмийн 139.55(a)(2)(ii)-р зүйлийг, хэрэв аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хариуцсан удирдах албан тушаалтны оронд тухайн байгууллага дотоод чанарын хяналтын баталгаа хариуцсан удирдах ажилтантай бол

(ii) Энэ дүрмийн 139.75-р зүйлийн дагуу аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог тогтоох, хэрэгжүүлэх, хадгалахын оронд байгууллага энэхүү дүрмийн 139.557 –р зүйлд шаардсан дотоод чанарын хяналтын систем тогтоосон бол:

- (iii) Энэ дүрмийн 139.77(a)(1A)-р зүйл:
 - (iv) дүрмийн 139.77(a)(3)(ii)-р зүйл:
 - (v) дүрмийн 137.77(a)(6A)-р зүйл; гэхдээ
- (2) 2018 оны 7-р сарын 30-ны дотор ИНЕГ-аас гаргасан маягтыг бөглөнхэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт Даргад ирүүлнэ.
- (i) ААУТ-г хэрэгжүүлэх төлөвлөсөн огноог багтаасан байна.
 - (ii) энэ дүрмийн 139.75-д шаардсан байгууллага аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй талаар тайлбар
- (c) Дарга шаардлага хангасан гэж үзвэл -
- (1) байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах болон
 - (2) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноог тогтооно.
- (d) Тодорхой байх үүднээс аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноо нь Дарга зөвшөөрөл олгосон огноо байна.
- (e) Энэ дүрмийн 139.553(c)(2)-ын дагуу хэрэгжүүлэх өдрийг тогтоохдоо Дарга дараах зүйлсийг харгалзан үзнэ:
- (1) байгууллагын чадамж
 - (2) байгууллагын бүтэц зохион байгууллалт
 - (3) байгууллагын үйл ажиллагаануудтай холбоотой гардаг эрсдэлүүд
 - (4) аливаа гэрчилгээний хугацаа сунгах огноо
 - (5) аливаа нөөц эсхүл байгууллагын ажлын хуваарийн хувьд байгууллага эсхүл эрх бүхий байгууллага эсхүл хоёуланд нь үзүүлж болох нөлөө
 - (6) хэрэгжүүлэх хугацаа нь 2021 оны 2-р сарын 1-ээс хойшгүй байна.
- (f) Хэрэв байгууллага нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч бол гэрчилгээ хүссэн өргөдлөө аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт ирүүлнэ.
- (g) Энэ дүрэм 2021 оны 2-р сарын 1-ны өдөр хүчингүй болно.

139.555 Хязгаарлагдмал аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч, өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны шилжилт

- (a) Энэ дүрэм нь дараахи байгууллагад хамаарна.

- (1) Хязгаарлагдмал аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч
- (2) Хязгаарлагдмал аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ хүсч өргөдөл гаргагч
 - (b) 2021 оны 2-р сарын 1-ээс өмнө энэ дүрмийн заалт хамаарах байгууллага нь—
 - (1) дараах шаардлагыг биелүүлэх шаардлагагүй
 - (i) Энэ дүрмийн 139.401(а)(2)(ii)-р зүйлийг, хэрэв аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хариуцсан удирдах албан тушаалтны оронд байгууллага дотоод чанарын хяналтын баталгаа хариуцсан удирдах ажилтантай бол
 - (ii) 139.409–р зүйлийн дагуу аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог тогтоох, хэрэгжүүлэх, хадгалахын оронд байгууллага энэхүү дүрмийн 139.557 –р зүйлд шаардсан дотоод чанарын хяналтын системтогтоосон бол
 - (iii) дүрэм 139.417(а)(1А):
 - (iv) дүрэм 139.417(а)(3)(ii):
 - (v) дүрэм 137.417(а)(6А); гэхдээ
 - (2) 2018 оны 7-р сарын 30-ны дотор ИНЕГ-ын гаргасан маягыг бөглөн хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт Даргад ирүүлсэн байна.
 - (i) ААУТ-г хэрэгжүүлэх төлөвлөсөн огноог багтаасан байна.
 - (ii) энэ дүрмийн 139.409-д шаардсан байгууллага аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй талаар тайлбар

(с) Дарга шаардлага хангасан гэж үзвэл -

 - (1) байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах болон
 - (2) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноог тогтооно.
 - (d) Тодорхой байх үүднээс аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноо нь Дарга зөвшөөрөл олгосон огноо байна.
 - (e) Энэ дүрмийн 139.555(с)(2)-ын дагуу хэрэгжүүлэх өдрийг тогтоохдоо Дарга дараах зүйлсийг харгалзан үзнэ:
 - (1) байгууллагын чадамж
 - (2) байгууллагын бүтэц зохион байгууллалт
 - (3) байгууллагын үйл ажиллагаануудтай холбоотой гардаг эрсдэлүүд

- (4) аливаа гэрчилгээний хугацаа сунгах огноо
- (5) аливаа нөөц эсхүл байгууллагын ажлын хуваарийн хувьд байгууллага эсхүл эрх бүхий байгууллага эсхүл хоёуланд нь үзүүлж болох нөлөө
- (6) хэрэгжүүлэх хугацаа нь 2021 оны 2-р сарын 1-ээс хойшгүй байна.

(f) Хэрэв байгууллага нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч бол гэрчилгээ хүссэн өргөдлөө аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт ирүүлнэ.

(g) Энэ дүрмийн зүйл 2021 оны 2-р сарын 1-ны өдөр хүчингүй болно.

139.557 Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч, өргөдөл гаргагчийн чанарын дотоод хяналтын баталгааны шилжилт

(a) Энэ дүрмийн 139.551(b)(1)(ii), 139.553(b)(1)(ii), 139.555(b)(1)(ii)–р зүйлүүдэд шаардсан дотоод чанарын удирдлагын системийг дүрмийн шаардлагыг биелүүлэх, мөрдөх, байгууллагын чадамж, нийцлийг ханган бататгахын тулд тогтоосон байна.

(b) Чанарын дотоод хяналтын баталгааг хариуцсан удирдах ажилтан нь гүйцэтгэх ерөнхий захиралтай агаарын хөлгийн нислэгийн аюулгүй ажиллагаа, аэродром, түүний байгууламж, үйлчилгээнд нөлөөлөх асуудлаар шууд харьцах боломжтой байна.

(c) Энэ дүрэм 2021 оны 2-р сарын 1-ны өдөр хүчингүй болно.

Хавсралт А – Аэродромын бодит үзүүлэлтүүд

А.1 ТАЗ –ны бодит үзүүлэлтүүд

(a) ТАЗ ын урт нь:—

- (1) Нислэгийн зурвасны төгсгөлөөс цааш үргэлжлэн хамгийн багадаа 90 м зайд байна.
- (2) Хэрэв газрын нөхцөл боломжтой бол—
 - (i) Нислэгийн зурвасны төгсгөлөөс цааш үргэлжлэн хамгийн багадаа 240 м зайд эсхүл
 - (ii) (a)(1) –д шаардсан 90 м –ээс (a)(2)(i) –д шаардсан 240 м –ийн хооронд аль болох боломжтой урт зайд байна.

(b) ТАЗ-ны өргөн —

- (1) Хамаарах ХБЗ-ны өргөний хэмжээнээс хамгийн багадаа хоёр дахин өргөн байх ба ХБЗ-ны тэнхлэгийн үргэлжлэлээс хоёр талдаа тэгш хэмтэй хэмжээтэй байрлана.
- (2) Хэрэв боломжтой нөхцөлд хамаарах нислэгийн зурвасны тэгшилсэн хэсгийн өргөнтэй тэнцүү өргөнтэй байна.

(c) ТАЗнь—

- (1) Онгоц ХБЗ–нд хүрэлгүй буух, ХБЗ-наас давж гарах үеийн эвдрэл, гэмтлийн эрсдлийг бууруулахаар тэгшилсэн ба цэвэрлэгдсэн байна.
- (2) Хэрэв боломжтой нөхцөлд онгоц ХБЗ –нд хүрэлгүй буух, ХБЗ-наас давж гарах үед аюулд учруулах аливаа объектгүй баригдсан байна.

(d) ТАЗ нь ХБЗ-ны ойртолтын эсхүл хөөрөлтийн өндөр авах гадаргуутай давхцахгүй байна.

(e) Хэрэв ТАЗ нь дагуу налууутай бол—

- (1) Уруудсан налууугийн хэмжээ 5 % -аас хэтрэхгүй байна.
- (2) Налуугийн өөрчлөлт тохиромжтой, аажим алгуур байна.
- (3) Гэнэтийн өөрчлөлт, налууугийн огцом өөрчлөлтөөс зайлсхийх шаардлагатай.

(f) Хэрэв ТАЗ нь хөндлөн нөлуутай бол —

- (1) Өгсөх уруудах налууугийн хэмжээ 5 % -иас хэтрэхгүй байна.
- (2) Налуугийн өөрчлөлт аль болох алгуур байх нь тохиромжтой.

Хавсралт В - Хяналтын код

- (а) Аэродромын хяналтын код нь үсгэн ба тоон кодоос бүрдэх бөгөөд аэродром төлөвлөлтийн зорилгоор ашиглах ба тухайн аэродромын байгууламжид зориулсан онгоцны үзүүлэлтэд тохируулан сонгож тодорхойлно.
- (б) Аэродромын хяналтын тоон ба үсгэн код нь Энэ дүрмийн Хүснэгт В-1-д заагдсан утгыг илэрхийлнэ.
- (с) Элемент 1 –ийн тоон кодын утгыг хүснэгт В-1-ийн 1-р баганад заасан тухайн зурвасыг ашиглах онгоцнуудын хяналтын талбайн уртын хамгийн өндөр утгатай тохирох кодыг ашиглаж тогтооно.

Тайлбар. Онгоцны хяналтын талбайн уртыг тодорхойлох нь зөвхөн тоон кодыг сонгоход зориулсан ба шаардагдах зурвасын уртад нөлөөлөхөд зориулагдаагүй болно.

- (д) Элемент 2 –ийн үсгэн кодын утгыг хүснэгт В-1 –ийн 3 –р баганад үзүүлсэн хэмжээнээс сонгох бөгөөд тухайн аэродромд ашиглахаар төлөвлөсөн онгоцнуудын далавчны тэлцийн хэмжээ эсхүл үндсэн тулгуур дугуйн гадна талын тэлцийн хэмжээнээс их хэмжээтэйд нь тохирох үсгэн кодын аль өндөр үсгэн кодтойгсонгож тогтооно.

Хүснэгт В-1. Аэродромын хяналтын код

Кодын элемент 1		Кодын элемент 2		
Тоон код	Онгоцны хяналтын талбайн урт	Үсгэн код	Далавчны тэлц	Үндсэн тулгуур дугуйн гадна талын тэлц
(1)	(2)	(3)	(4)	(5)
1	800 м-ээс бага	A	15 м хүртэл, гэхдээ 15 м –ийг оруулахгүй	4.5 м хүртэл, гэхдээ 4.5 м –ийг оруулахгүй
2	800 м –ээс 1200 м хүртэл, гэхдээ 1200 м-ийг оруулахгүй	B	15 м –ээс 24 м хүртэл, гэхдээ 24 м-ийг оруулахгүй	4.5 м –ээс 6 м хүртэл, гэхдээ 6 м-ийг оруулахгүй
3	1200 м –ээс 1800 м хүртэл, гэхдээ 1800 м-ийг оруулахгүй	C	15 м –ээс 24 м хүртэл, гэхдээ 24 м-ийг оруулахгүй	6 м –ээс 9 м хүртэл, гэхдээ 9 м-ийг оруулахгүй
4	1800 м болон түүнээс урт	D	36 м –ээс 52 м хүртэл, гэхдээ 52 м-ийг оруулахгүй	9 м –ээс 14 м хүртэл, гэхдээ 14 м-ийг оруулахгүй
		E	52 м –ээс 65 м хүртэл, гэхдээ 65 м-ийг оруулахгүй	9 м –ээс 14 м хүртэл, гэхдээ 14 м-ийг оруулахгүй
		F	65 м –ээс 80 м хүртэл, гэхдээ 80 м-ийг оруулахгүй	14 м –ээс 16 м хүртэл, гэхдээ 16 м-ийг оруулахгүй

Тайлбар: Хүснэгтийн 5-р баганад үзүүлсэн үндсэн дугуйны гадна талын тэлц, тулгуур дугуйны гадна талын ирмэг хоорондын зай юм.

Хавсралт С – Бодит үзүүлэлтүүд

С.1 ХБЗ-ны гадаргуу

(a) ХБЗ-ны гадаргуу хучилтын гадаргуугийн үрэлтийн үзүүлэлтэд нөлөөлөх эсхүл агаарын хөлгийн хөөрөлт буултанд сөрөг нөлөө үзүүлэхгүйтэгш баригдсан байна.

(b) Хучилттай зурвас Даргын тогтоосон үрэлтийн хамгийн бага түвшний хэмжээнд эсхүл түүнээс дээш үрэлтийн үзүүлэлттэй байхаар баригдсан эсхүл хүчитгэсэн байна.

С.2 Нислэгийн талбай \ Зурвас \

ХБЗ болон түүний зогсоох зурвасууд нислэгийн зурваст багтана.

С.2.1 Нислэгийн талбайн / Зурвасны/ урт

Нислэгийн зурвас нь ХБХЗ –ны босгоноос өмнө ба ХБХЗ-ны эцсээс цааш эсхүл зогсоох зурвасны төгсгөлөөс цааш хамгийн багадаа

- (1) хүснэгт В 1 –д заагдсан Аэродромын Хяналтын Код 3 эсхүл 4 бол 60 м зайд эсхүл
- (2) хүснэгт В 1 –д заагдсан Аэродромын Хяналтын Код 2 бол 30 м эсхүл
- (3) хүснэгт В 1 –д заагдсан Аэродромын Хяналтын Код 1 бол 10 м зайд үргэлжилнэ.

С.2.2 Нислэгийн Зурвасны өргөн

Нислэгийн зурвас нь энэ хавсралтын хүснэгт С – 1 –д үзүүлсэн хамгийн бага зайд, хамаарах ХБЗ –ны тэнхлэгээс хоёр тал руугаа ижил хэмжээнд, нийт уртын хэмжээнд үргэлжилнэ.

Хүснэгт С – 1 Нислэгийн зурвасны өргөний минимум хэмжээ

Хяналтын тоон код	ХБЗ-ны төрөл	Зай хэмжээ
3 эсхүл 4	Нарийвчлалтай ойртолтын	150 m
3 эсхүл 4	Нарийвчлалгүй ойртолтын тоноглолтой	75 m
3 эсхүл 4	Тоноглолгүй ойртолт	75 m
1 эсхүл 2	Нарийвчилсан ойртолт	75 m
1 эсхүл 2	Нарийвчилсан бус тоноглолтой ойртолт	75 m
2	Тоноглолгүй ойртолт	40 m

1	Тоноглолгүй ойртолт	30 м
---	---------------------	------

С.2.3 Нислэгийн зурвас дээрхи объектууд

(а) Хэврэг байдлын шаардлага хангасан аэронавигацийн зориулалтаар ашиглах ил харааны тоноглол, хэрэгслээс бусад аливаа хөдөлгөөнгүй объект нислэгийн талбайн хэмжээнд дор дурдсан зайд байхыг хориглоно.

- (1) Энэ хавсралтын Хүснэгт В-1 –д заасан CAT I II III ангиллын нарийвчилсан ойртолттой зурвастай, хяналтын тоон код 4 , үсгэн код F тэй аэродромын хувьд ХБЗ-ны тэнхлэгээс хоёр тийш 77.5 м зайд эсхүл
- (2) Энэ хавсралт В - ын Хүснэгт В-1 –д заасан CAT I II III ангиллын нарийвчилсан ойртолттой зурвастай, хяналтын тоон код 3 эсхүл 4 тэй аэродромын хувьд ХБЗ-ны тэнхлэгээс хоёр тийш 60 м зайд, эсхүл
- (3) Энэ хавсралт В-ын Хүснэгт В-1 –д заасан CAT I ангиллын нарийвчилсан ойртолттой зурвастай, хяналтын тоон код 1 эсхүл 2 -той аэродромын хувьд ХБЗ-ны тэнхлэгээс хоёр тийш 45 м зайд

(b) Онгоц хөөрч буух зорилгоор зурвасыг ашиглаж байх үед (а) зүйлд заагдсан зайд аливаа хөдөлгөөнтэй объект байхыг хориглоно.

С.2.4 Нислэгийн зурвасны гадаргууг тэгшлэх

Нислэгийн Зурвасны ХБЗ, түүний хөвөө, эсхүл зогсоох зурвастай нийлэх хэсгийн гадаргуу ХБЗ, түүний хөвөө эсхүл зогсоох зурвасны гадаргуутай нэг шугаман дээр буюу тэгш байна.

С.3 ХБЗ-ны эргэлтийн талбай

ХБЗ-ны төгсгөлд холбох явгалах зам байхгүй эсхүл эргэлт хийх боломжтой явгалах замгүй ба Хавсралт В –ийн Хүснэгт В-1 –д заасан D, E эсхүл F үсгэн код бүхий аэродромд тухайн ангилалд тохирсон онгоц 180 градус эргэлт хийх боломжтой эргэлтийн талбайг хийнэ.

С.3.1 ХБЗ-ны эргэлтийн талбайн төлөвлөлт

Эргэлтийн талбайг төлөвлөхдөө онгоцны нисгэгчийн бүхээг эргэлтийн талбайн тэмдэглэгээ дээр байнга байж байхаар ба онгоцны аль ч тулгуур дугуй эргэлтийн талбайн хязгаар ирмэг хоорондын зай 4.5 м –ээс доошгүй зайтай байхаар тооцно.

С.3.2 ХБЗ-ны эргэлтийн талбайн гадаргуу

Тухайн эргэлтийн талбайг хэрэглэж буй агаарын хөлөгт гэмтэл учруулж магадгүй аливаа тэгш жигд бус гадаргуу эргэлтийн талбайд байхыг хориглоно.

С.4 Зогсоох талбай

Зогсоох талбайнөргөннь хамаарч буй ХБЗ-ны өргөнтэй тэнцүү хэмжээтэй байна.

С.5 Явгалах замууд

Тус дүрмийн 139.5(аа) –д заасан аэродромын явгалах замуудыг төлөвлөхдөө нисгэгчийн бүхээг тухайн онгоцны явгалахад зориулсан явгалах замын тэнхлэгийн шугаман тэмдэглэгээ дээр байнга байж байхаар ба үндсэн тулгуурын гадна талын дугуй болон явгалах замын хажуу ирмэг хоорондын тусгаарлах зай хүснэгт С -2 –д тогтоосноос багагүй байхаар тооцно.

Хүснэгт С-2.Явгалах замын хязгаарын тусгаарлах зайнууд

Үсгэн код	Тусгаарлах зай хэмжээ
A	1.5 m
B	2.25 m
C	3 m,хэрэв явгалах замыг дугуй хоорондын зай нь 18 м–ээс ихгүй урттай агаарын хөлөгт ашиглах бол, эсхүл 4.5 m,хэрэв явгалах замыг дугуй хоорондын зай нь 18 м –тэй тэнцүү эсхүл их хэмжээтэй агаарын хөлөгт ашиглах бол
D	4.5 m
E	4.5 m
F	4.5 m

Тайлбар: Дугуйны суурь гэж урд дугуйны голоос үндсэн тулгуур дугуйны геометрийн төв цэг хүртэлх зайг хэлнэ.

С.6 Гүүрэн явгалах зам

Явгалах замын тэнхлэгийн шугамтай перпендикуляр хэмжсэн, ашиглах агаарын хөлгөөс ирэх ачааллыг даах чадвартай явгалах замын хэсгийн өргөн нь явгалах замын зурвасны тэгшлэх талбайн өргөнөөс багагүй өргөнтэй байна. Гэхдээ агаарын хөлөг явгалахад аюулгүйг нотолсон хажуугийн хамгаалах батлагдсан арга хэмжээ авагдсан бол бага байж болно.

С.7 Явгалах замын зурвас

Онгоцны зогсоолын явгалах шугамнаас бусад явгалах замууд явгалах зурваст багтсан байна.

С.8 Хүлээх байрлалууд

(а) ХБЗ-ны хүлээх байрлал нь—

(1) явгалах зам дээр, явгалах зам ба ХБЗ-ны огтлолцол дээр болон

(2) ХБЗ өөр ХБЗ –тай огтлолцох уулзварт эхний ХБЗ нь стандарт явгалах маршрутын нэг хэсэг болон төлөвлөгдсөн бол

(b) ХБЗ-ны хүлээх шугам хэрэв байршил эсхүл явгалах замын чиглэл нь явгалж буй онгоц эсхүл машин техник саадаас хязгаарлах гадаргуугаас гарах нөхцөлд эсхүл радио навигацийн тоноглолын үйл ажиллагаанд садаа болох нөхцөл үүсэхээр бол явгалах зам дээр байрлана.

(c) Авто машин явах замын хүлээх байрлалыг ХБЗ-тай огтлолцох замын уулзварт хийсэн байна.

Хавсралт D — Саадыг хязгаарлах ба зайлуулах

D.1 Саадаас хязгаарлах гадаргуу

(a) Доорхи саадаас хязгаарлах гадаргууг ХБЗ бүрд тогтоосон байх шаардлагатай. Үүнд:

(1) Конус хэлбэрийн гадаргуу

(2) Дотоод хэвтээ гадаргуу

(3) Ойртолтын гадаргуу

(4) Шилжих гадаргуу

(b) Нарийвчилсан ойртолттой CAT II эсхүл CAT III ангиллын ХБЗ-тай бол дор дурдсан саадаас хязгаарлах нэмэлт гадаргууг тогтоосон байна.

(1) Дотоод ойртолтын гадаргуу

(2) Дотоод шилжилтийн гадаргуу

(3) Аргагүйдсэн буултын гадаргуу

(c) Тоноглолгүй ХБЗ бүхий аэродромын хувьд шинэ байгууламж эсхүл байгууламжийн өргөтгөл нь одоо байгаа үл хөдлөх объектоор халхлагдсан эсхүл нисэхийн судалгааны дагуу тухайн объект онгоцны нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй эсхүл онгоцны нислэгийн тогтмол үйл ажиллагаанд иххэмжээний нөлөөгүй гэж тогтоосноос бусад ойртолтын гадаргуу эсхүл шилжих гадаргуугаас өндөр шинэ байгууламж эсхүл одоо байгаа байгууламжийг өргөтгөхийг хориглоно.

(d) Нарийвчлалгүй ойртолтын ХБЗ бүхий аэродромын хувьд шинэ байгууламж эсхүл байгууламжийн өргөтгөл нь одоо байгаа үл хөдлөх объектоор халхлагдсан эсхүл нисэхийн судалгааны дагуу тухайн объект онгоцны нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй эсхүл онгоцны нислэгийн тогтмол үйл ажиллагаанд ихээр нөлөөлөхгүй гэж тогтоосноос бусад дотоод гадаргуугийн

хязгаараас 3000 м зайд ойртолтын гадаргууэсхүл шилжих гадаргуугаас өндөр шинэ байгууламж барих эсхүл одоо байгаа байгууламжийг өргөтгөхийг хориглоно.

(e) Нарийвчлалтай ойртолттой зурвасын хувьд нислэгийн талбайд зайлшгүй байршиж ажиллах хэврэг хийцтэй объектоос бусад, дотоод ойртолтын гадаргуу, дотоод шилжилтийн гадаргуу эсхүл аргагүйдсэн буултын гадаргуугаас дээш аливаа хөдөлгөөнгүй объект байрлуулахыг хориглоно. Онгоц буулт үйлдэж байх үед эдгээр гадаргуу дээр хөдөлгөөнтэй объект байрлахыг хориглоно.

(f) Нарийвчлалтай ойртолттой зурвасын хувьд шинэ байгууламж эсхүл байгууламжийн өргөтгөл нь одоо байгаа үл хөдлөх объектоор халхлагдсан эсхүл нисэхийн судалгааны дагуу тухайн объект онгоцны нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй эсхүл онгоцны нислэгийн тогтмол үйл ажиллагаанд ихээр нөлөөлөхгүй гэж тогтоосноос бусад ойртолтын гадаргуу эсхүл шилжих гадаргуугаас өндөр шинэ байгууламж барих эсхүл одоо байгаа байгууламжийг өргөтгөхийг хориглоно.

D.2 Хөөрөлт үйлдэх гадаргуу

(a) Хөөрөлт үйлдэх ХБЗ –т хөөрөлтийн өгсөх гадаргууг тогтоосон байна.

(b) Шинэ байгууламж эсхүл байгууламжийн өргөтгөл нь одоо байгаа үл хөдлөх объектоор халхлагдсан эсхүл нисэхийн судалгаагаар тухайн объект онгоцны нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй эсхүл онгоцны нислэгийн тогтмол үйл ажиллагаанд их хэмжээгээр нөлөөлөхгүй гэж тогтоосноос бусад хөөрөлтийн өгсөх / өндөр авах / гадаргуугаас дээш шинэ байгууламж барих эсхүл одоо байгаа байгууламжийг өргөтгөхийг хориглоно.

Хавсралт E Ил харааны навигацийн тоноглол, хэрэгслүүд

E.1 Салхины чиглэл заагч

(a) Салхины чиглэл заагч хучилттай зурвасын босго бүрийн харалдаа байрлана.

(b) Хэрэв хучилттай ХБЗ –г шөнийн нислэгт ашиглах бол энэ хэсгийн (a) –д шаардсан салхины чиглэл заагчуудын хамгийн багадаа нэгийг гэрэлтүүлсэн байна.

E.2 Тэмдэглэгээ

E.2.1 Өнгө

(a) ХБЗ-ны тэмдэглэгээ цагаан өнгөтэй байна.

(b) Явгалах зам, ХБЗ-ны эргэлтийн хэсэг, онгоцны зогсоолын тэмдэглэгээ шар өнгөтэй байна.

(с) Перроны аюулгүйн шугамууд онгоцны зогсоолын тэмдэглэгээнд хэрэглэж байгаагаас эрс ялгаатай, тод ялгарч харагдах өнгөтэй байх ёстой.

E.2.2 ХБЗ-ны тэмдэглэгээ

ХБЗ-ны чиглэл заагч, тэнхлэгийн шугам, босгоны тэмдэглэгээ бүх хучилттай зурвас дээр тэмдэглэгдсэн байна.

E.2.3 ХБЗ-ны тэмдэглэгээний давхцал

(а) Хоёр эсхүл түүнээс дээш тооны зурвасны огтлолцсон хэсэг дээр гол буюу үндсэн зурвасны хажуугийн хязгаарын тэмдэглэгээнээс бусад тэмдэглэгээг хийх ба бусад зурвасууд дээр тэмдэглэгээ хийхгүй. Гол буюу үндсэн зурвасны хажуугийн хязгаарын тэмдэглэгээг огтлолцсон хэсэгт үргэлжлэн тэмдэглэх эсхүлүзүүлэхгүй байж болно.

(б) ХБЗ ,явгалах замын огтлолцол дээр ХБЗ-ны хажуугийн хязгаарын тэмдэглэгээг үзүүлэхгүй байхаас бусад үед ХБЗ-ны тэмдэглэгээг бүрэн үзүүлж, явгалах замын тэмдэглэгээг үзүүлэхгүй байж болно.

E.2.4 Хөндлөн зураас

Хучилттай зурвасны босго шилжсэн тохиолдолд эсхүл хучилттай зурвасны босгоны ирмэг нь тэнхлэгийн шугамтай тэгш хэмтэй бус тохиолдолд нэмэлт хөндлөн зураасаар ХБЗ-ны босгоны тэмдэглэгээг тодотгосон байна.

E.2.5 Чиг заагч сум

Хэрэв хучилттай зурвасны босгыг бүрмөсөн шилжүүлсэн нөхцөлд чиг заагч сум заасан тэмдэглэгээ зурвасны шилжсэн босго хүртэлх зайд хийгдсэн байна.

E.2.6 Шүргэх цэгийн тэмдэглэгээ

Хавсралт В –д заагдсаны дагуу хэрэв хяналтын код 2, 3 эсхүл 4 ба хучилттай, тоноглолтой зурвасны ойртолтын төгсгөл бүрд шүргэх цэгийн тэмдэглэгээ хийгдсэн байна.

E.2.7 Буултын бүсийн тэмдэглэгээ

Хавсралт В-д заасны дагуу аэродромын хяналтын код 2, 3 эсхүл 4 ба нарийвчлалтай ойртолтын, хучилттай зурвастай бол ХБЗ-ны буултын бүсэд буултын бүсийн тэмдэглэгээ хийгдсэн байна.

Е.2.8 ХБЗ-ны хажуугийн хязгаарын тэмдэглэгээ

ХБЗ-ны хажуугийн хязгаарын тэмдэглэгээ хучилттай зурвасны босгонуудын хооронд ХБЗ-ны хязгаар ба хөвөөний хооронд эсхүл орчмын газрын өнгөнөөс ялгарал байхгүйүед хийгдсэн байна.

Е.2.9 Явгалах замын тэнхлэг / төв / шугамын тэмдэглэгээ

(a) Хавсралт В –д тогтоосны дагуу хяналтын код 3 эсхүл 4 ба хатуу хучилттай явгалах зам, мөстөлт арилгах зогсоол, перрон дээр ХБЗ-ны тэнхлэг шугамаас онгоцны зогсоол хоорондүргэлжилсэнзааварчилгаар хангахын тулдявгалах замын тэнхлэг шугамын тэмдэглэгээ хийгдсэн байна.

(b) Уг аэродромын ХБЗ нь стандарт явгалах маршрутын хэсэг бол явгалах замын тэнхлэгийн тэмдэглэгээ хучилттай зурвас дээр хийгдсэн байна. Үүнд:

- (1) Хэрэв ХБЗ-ны тэнхлэгийн шугамын тэмдэглэгээ байхгүй бол эсхүл
- (2) Хэрэв ХБЗ-ны тэнхлэгийн шугам явгалах замын тэнхлэгийн шугамтай давхцахгүй бол

(c) Явгалах замын өргөсгөсөн тэмдэглэгээг явгалах зам ба ХБЗ –ны огтлолцол бүрт хийсэн байна.

Е.2.10 ХБЗ-ны эргэлтийн хэсгийн тэмдэглэгээ

ХБЗ-ны эргэлтийн хэсэгтэй бол онгоц ХБЗ-ны тэнхлэгийн шугамын дагуу 180 градус бүтэн эргэлт хийхэд заах, чиглүүлэхэд зориулсан ХБЗ-ны эргэлтийн хэсгийн тэмдэглэгээ хийгдсэн байна.

Е.2.11 ХБЗ-ны хүлээх байрлалын тэмдэглэгээ

Хучилттай зурвас эсхүл явгалах зам дээр ХБЗ-ны хүлээх байрлалын тэмдэглэгээ хүлээх байрлалын дагуу хийгдсэн байна.

Е.2.12 VOR шалгах цэгийн тэмдэглэгээ

Хэрэв VOR шалгах цэг байгуулагдсан бол VOR шалгах цэгийн тэмдэглэгээ хийгдсэн байна.

Е.2.13 Автозамын хүлээх байрлалын тэмдэглэгээ

Автозамын хүлээх байрлалын тэмдэглэгээХБЗ руу нэвтрэх бүх хучилттай замын гадаргуу дээр тэмдэглэгдсэн байх ёстой.

Е.2.14 Зайлшгүй хийгдэх заах тэмдэглэгээ

Заах тэмдэгт суурилуулах боломж, нөхцөлгүй үед хучилтын гадаргуу дээр зайлшгүй заах тэмдэглэгээ хийгдсэн байна.

Е.2.15 Мэдээлэх тэмдэглэгээ

Мэдээлэх тэмдэгт байрлуулах ёстой ч байрлуулах боломжгүй нөхцөлд мэдээлэх тэмдэглэгээг хучилтын гадаргуу дээр тэмдэглэсэн байна.

Е.3 Гэрлүүд

Е.3.1 Өргөгдсөн ойртолтын гэрлүүд

(а) ХБЗ-ны босгоноос 300 м -ийн ойртолтын гэрлийн системийн хэсгээс бусад өргөгдсөн гэрлүүд ба тэдгээрийн суурь бүтээц нь хэврэг байдлын шаардлага хангасан байна. Үүнд:

- (1) Хэрэв суурь бүтээцийн өндөр 12 м-ээс дээш бол хэврэг байдлын шаардлага зөвхөн орой хэсгийн 12 м –т хамаарна.
- (2) Хэрэв суурь бүтээц хэврэг бус хийцтэй объектоор хүрээлэгдсэн бол зөвхөн хүрээлсэн объектоос дээш өндөрсөн хэсэгт хэврэг байдлын шаардлага хамаарна.

(b) Хэрэв ойртолтын гэрлийн хэмжээ эсхүл суурь бүтээц хангалттай харагдахгүй байвал зохих будган тэмдэглэгээ хийгдсэн байна.

Е.3.2 Өргөгдсөн гэрлүүд

ХБЗ, зогсоох зурвас, явгалах замын өргөгдсөн гэрлүүд хэврэг байна. Тэдгээрийн өндрийн хэмжээжөт онгоцны хөдөлгүүрийн гаднах хамгаалалтаас болон сэнсний үзүүрээс хангалттай зайг хадгалахаар бага байна.

Е.3.3 Гадаргуугийн гэрлүүд

ХБЗ, зогсоох зурвас, явгалах зам ба перроны гадаргууд сууж байрлах гэрлүүдийн эд анги дээгүүр өнгөрч буй агаарын хөлгийн дугуйнаас ирэх ачааллыг дааж, агаарын хөлөгт эсхүл гэрэлт өөрт нь эвдрэл гэмтэл учруулахааргүй төлөвлөгдөж, суурилагдсан байна.

Е.3.4 Гэрлийн чадал ба хяналт

(a) ХБЗ-ны гэрлийн чадал нь алсын барааны харагдацын минимум нөхцлийг хангаж байхаар , ХБЗ-ыг хэрэглэхэд зориулсан гадна гэрэл байвал тэдгээр нь ойртолтын гэрлийн системийн хамгийн ойрын хэсэгтэй тохирохоор байна.

(b) Тохиромжтой чадлын хяналт нь голлох нөхцлийн шаардлагыг хангаж, гэрлийн хүчин чадлын тохиргоо хийх боломжтой хийгдсэн байна. Дараахи системүүд суурилагдсан бол тохиромжтой чадлаар ажиллаж байхыг бататгахын тулд тусдаа чадлын хяналт эсхүл өөр тохирох аргачлалаархангагдсан байна.

- (1) Ойртолтын гэрлийн систем
- (2) ХБЗ-ны хажуугийн гэрлүүд
- (3) ХБЗ-ны босгоны гэрлүүд
- (4) ХБЗ-ны төгсгөлийн гэрлүүд
- (5) ХБЗ-ны тэнхлэгийн шугамын гэрлүүд
- (6) ХБЗ-ны суултийн бүсийн гэрлүүд
- (7) ЯЗ-ын тэнхлэгийн шугамын гэрлүүд

Е.3.5 Аэродромын гэрэлт дохио

Аэродромын гэрэлт дохио шөнөөр ашигладаг аэродромд дараахи нөхцлүүдээс нэг эсхүл түүнээс олон үүсч байвал суурилуулна.

- (1) Ил харааны нөхцлөөр ихэвчлэн ашигладаг бол
- (2) Хараа багасах нөхцлийн давтамж ихтэй бол
- (3) Эргэн тойрны нөхцөл эсхүл гэрлүүдээс шалтгаалж уг аэродромын байрлалыг агаараас тогтооход хүндрэл үүсдэг бол

Е.3.6 Ойртолтын гэрлийн системүүд

(a) Хэрэв бодит шалтгаан байгаа нөхцөлд, SALS/ энгийн ойртолтын гэрлийн систем / гэрлийг нарийвчлалтай бус ойртолтын зурвастай аэродромд суурилуулна. Гэхдээ зөвхөн үзэгдэх орчин, хараа сайн нөхцөлд ашигладаг бол эсхүл бусад ил харааны тэмдэгтүүд хангалттай зааварчилгаа өгч байгаа нөхцөлд SALS суурилуулах шаардлагагүй.

(b) Хэрэв бодит шалтгаан байгаа нөхцөлд, нарийвчлалтай ойртолтын CAT I ХБЗ-тай аэродромд нарийвчлалтай ойртолтын CAT I гэрлийн системийг суурилуулна.

(c) Нарийвчлалтай ойртолтын CAT II болон III гэрлийн системийг нарийвчлалтай ойртолтын CAT II эсхүл CAT III ХБЗ –тай аэродромд суурилуулсан байх шаардлагатай.

E.3.7 VASIS/ Ил харааны ойртолтын налуу заагч системүүд/

(a) Ил харааны ойртолтын налуу заагч системийг ХБЗ-ны ойртолтод хэрэглэх эсхүл ХБЗ нь бусад ойртолтын тоноглолоор тоноглогдсон эсхүл ил харааны бус тоноглолоор тоноглогдсон ба дараахи нэг эсхүл илүү нөхцөл үүсч байвал суурилагдсан байна.

- (1) ХБЗ –ыг тийрэлтэт, сэнст тийрэлтэт эсхүл ойролцоо ойртолтын нөхцөл шаарддаг бусад онгоц ашиглах бол
- (2) Дор дурдсан нөхцлөөс шалтгаалж ямарч маягийн онгоцны нисгэгч ойртолтын нөхцлийг шинжихэд хүндрэл учирч байвал, үүнд:
 - (i) Усан дээгүүр ойртолт хийх үед харааны баримжаа алдагдах нөхцөл үүссэн бол эсхүл өдрийн цагт онцгойрох зүйлгүй газар орны нөхцөлд эсхүл шөнийн нислэгт ойртолтын бүсэд хангалттай хэмжээний баримжаалах гэрэлгүй нөхцөлд, эсхүл
 - (ii) ХБЗ-ны налуугаас эсхүл төөрч болох эргэн тойрны газрын байрлалаас үүссэн буруу чиглэлийн мэдээллээс шалтгаалж
- (3) Онгоц хэвийн ойртолтын траектороос доогуур өндөр алдах үед ойртолтын бүсэд байгаа объект түүнд бодит аюул учруулж болох ялангуяа тийм объект байгааг анхааруулах өөр бусад тэмдэгт тэмдэглэгээ эсхүл ил харааны бус тэмдэгтгүй нөхцөлд:
- (4) ХБЗ–ны аль ч төгсгөлийн газар зүйн нөхцөл нь ХБЗ–ыг онгоцдавж суух эсхүл дутуу суух үед ноцтой аюул учруулахаар бол:
- (5) Газрын нөхцөл байдал эсхүл голлох цаг уурын нөхцөл нь ойртолт үйлдэж буй онгоц хэвийн бус сэгсрэлт үзүүлэхээр бол

(b) Хавсралт В–д заасны дагуу аэродромын хяналтын код 3, эсхүл 4 гэж тодорхойлсон, энэ хэсгийн (a)(1) - (5) –р зүйлд шаардсан нөхцлүүдийн 1, эсхүл илүү нөхцөл бүрдсэн үед PAPI, T-VASIS эсхүл AT-VASIS суурилуулагдсан байна.

(c) Хавсралт В–д заасны дагуу аэродромын хяналтын код 1, эсхүл 2 гэж тодорхойлсон, энэ хэсгийн (a)(1) - (5) –р зүйлд шаардсан нөхцлүүдийн 1, эсхүл илүү нөхцөл бүрдсэн үед PAPI эсхүл APAPI суурилуулсан байна.

E.3.8 Саадаас хязгаарлах / хамгаалах / гадаргуу

(a) Саадаас хязгаарлах /хамгаалах/ гадаргуу VASIS суурилуулах зориулалтай нөхцөлд тогтоогдсон байна.

(b) Шинэ объект барих, эсхүл хуучин объектыг өргөтгөх нь одоо байгаа хөдөлгөөнгүй объектоор халхлагдахаас бусад нөхцөлд саадаас хязгаарлах гадаргуугаас дээш шинэ объект барих, эсхүл хуучин объектыг өргөтгөхийг хориглоно.

(с) Урьд нь суурилагдсан хөдөлгөөнгүй объектоор халхлагдсан, эсхүлнисэхийн судалгаагаар тухайн объект агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүйг тогтоосноос бусад саадаас хязгаарлах гадаргуугаас өндөр өргөгдсөн суурилагдсан объектуудыг буулгана.

(d) Хэрэв нисэхийн судалгаагаар саадаас хязгаарлах гадаргуугаас өндөр өргөгдсөн одоо байгаа объект агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхийг тогтоосон бол доорхи арга хэмжээнүүдийн аль нэгийг эсхүл нэгээс илүүг авна.

- (1) Ил харааны ойртолтын налуу заагч системийн ойртолтын налуу тохируулж дээшлүүлэх
- (2) Ил харааны ойртолтын налуу заагч системийн азимутын тархалтын хүрээг бууруулан тухайн объект цацрагийн хүрээнээс гарахаар болгох
- (3) Ил харааны ойртолтын налуу заагч систем ба ба холбогдох саадаас хязгаарлах гадаргуугийн тэнхлэгийг 5 градусаас ихгүйгээр шилжүүлэх
- (4) ХБЗ-ны босгыг тохируулж шилжүүлэх
- (5) Хэрэв 4-р зүйлд заасан арга хэрэглэх боломжгүй, тохиромжгүй бол ил харааны ойртолтын налуу заагч системийг босгыг огтлох өндөр объектыг нэвтрэх өндөртэй ижил өсгөхийн тулд ХБЗ-ны босгоноос цааш тохируулж шилжүүлэх

Е.3.9 ХБЗ-ны хажуугийн ба төгсгөлийн гэрлүүд

ХБЗ-ны хажуугийн ба төгсгөлийн гэрлүүдшөнөөр ашиглах зурвас эсхүл нарийвчлалтай ойртолтын зурвас бүхий өдөр эсхүл шөнөөр ашиглах зурвастай аэродромд суурилагдсан байна.

Е.3.10 ХБЗ-ны босгоны ба хөндлөн шугамын гэрлүүд

(a) Хажуугийн гэрлүүдээр тоноглогдсон ХБЗ нь тоноглолгүй эсхүл нарийвчлалгүй ойртолтын зурвастай ба босго шилжсэн, босгоны хажуугийн гэрэлтэй нөхцөлөөс бусад тохиолдолд ХБЗ-ны босгоны гэрлүүдтэй байна.

(b) Тоноглолгүй эсхүл нарийвчлалгүй ойртолтын зурвастай ба босго шилжүүлсэн, ХБЗ-ны босгоны гэрэл шаардлагатай боловч суурилагдаагүй үед босгоны хажуугийн хөндлөн шугамын гэрлүүдийг суурилуулсан байна.

Е.3.11 ХБЗ-ны тэнхлэг шугамын гэрлүүд

(a) ХБЗ-ны тэнхлэгийн шугамын гэрлүүдийг нарийвчлалтай ойртолтын II, эсхүл III категорийн ХБЗ-тай аэродромд суурилуулна.

(b) ХБЗ-ны тэнхлэгийн шугамын гэрлүүдийг ХБЗ-ны харагдацын нөхцөл 400м-ээс бага минимумтай аэродромд хөөрөлт үйлдэх шаардлагатай бол суурилуулна.

Е.3.12 ХБЗ-ны буултын бүсийн гэрлүүд

ХБЗ-ны буултын бүсийн гэрлүүднэрийвчлалтай ойртолтын II,эсхүл III категорийн ХБЗ-ны суултын бүсэд суурилуулна.

Е.3.13 Зогсоох замын/ хэсгийн / гэрлүүд

Зогсоох зурвасыгшөнөөр ашиглахнөхцөлд зогсоох зурвасны гэрлүүдийгсуурилуулна.

Е.3.14 Явгалах замын тэнхлэг шугамын гэрлүүд

(а) Явгалах замын тэнхлэг шугамын гэрлүүдийг зурваснаас гарах явгалах зам, явгалах зам, мөстөлт арилгах талбай ба перронд 350м-ээс бага ХБЗ-ны харагдацын нөхцөлтэй, ХБЗ-ны тэнхлэгийн шугам ба онгоцны зогсоолын хооронд үргэлжлэн заавраар хангахын тулдэдгээр гэрлүүд нь хөдөлгөөний эрчимжилт багаас шалтгаалан шаардлагагүй болон тэнхлэгийн шугамын будган тэмдэглэгээ хангалттай зааварчилж байхаас бусад нөхцөлд суурилуулсан байна.

(b) Явгалах замын тэнхлэг шугамын гэрлүүдийг ХБЗ стандарт явгалах маршрутын хэсэг болсон үед ба ХБЗ-ны харагдацын нөхцөл 350м –ээс бага үед явгалах нөхцөлд эдгээр гэрлүүд нь хөдөлгөөний эрчимжилт багаас шалтгаалан шаардлагагүй буюу тэнхлэгийн шугамын будган тэмдэглэгээ хангалттай зааварчилж байхаас бусад нөхцөлд суурилуулсан байна.

Е.3.15 Явгалах замын хажуугийн гэрлүүд

(а) Явгалах замын хажуугийн гэрлүүдийг, шөнөөр ашиглах зориулалттай хүлээх байрлал, мөстөлт арилгах талбай, перрон, бусад ижил төстэй талбайн хажуу талд, явгалах замын тэнхлэгийн шугамын гэрэлгүй шөнөөр ашиглах явгалах замд, үйл ажиллагааны онцлогийг харгалзан гадаргуугийн гэрэл, эсхүл өөр зүйлээр хангалттай зааварчилгаа өгөх боломжтой нөхцөлд явгалах замын хажуугийн гэрлүүд шаардлагагүй нөхцлөөс бусад үед суурилуулсан байна.

(b) Явгалах замын хажуугийн гэрлүүдийг ХБЗ стандарт явгалах маршрутын хэсэг болсон үед ба тухайн аэродром явгалах замын тэнхлэгийн шугамын гэрлүүдээр тоноглогдоогүй боловч шөнөөр ашиглах явгалах замтай бол суурилуулна.

Е.3.16 ХБЗ-ны эргэлтийн талбайн гэрлүүд

ХБЗ-ны эргэлтийн талбайн гэрлүүдийгагарын хөлөг ХБЗ-ны тэнхлэгтэй тохируулан 180 градус эргэлт хийх боломжоор хангахын тулд ХБЗ-ны харагдацын нөхцөл 350 м –ээс бага үед ашиглагдах зурвасны эргэлтийн талбайд үргэлжилсэн заавар өгөхийн тулд суурилуулсан байна.

Е.3.17 Зогс гэрлүүд

(а) “Зогс” гэрлүүд ХБЗ-ны харагдацын нөхцөл 550м-ээс бага үед ашиглагдах ХБЗ-ны хүлээх байрлал бүрд, дор дурдсанаас бусад нөхцөлд суурилагдсан байна:

- (1) Зохих тэмдэгт тэмдэглэгээ ба үйл ажиллагаа ХБЗ руу санаандгүйгээр, зөвшөөрөлгүй нэвтрэх боломжийг хязгаарлах нөхцлийг хангаж байгаа, эсхүл
- (2) ХБЗ-ны харагдацын нөхцөл 550м-ээс бага үеийн үйл ажиллагааны журам хязгаарлалт тогтоосон ба, хэрэв
 - (i) маневрлах талбайд нэг онгоц нэг цаг үед байгаа бол;
 - (ii) маневрлах талбайд байгаа машин техник шаардагдах хамгийн бага хэмжээнд байгаа бол.

(b) Нэгээс илүү “зогс” гэрэл хамааралтай явгалах зам, эсхүл ХБЗ-ны огтлолцол дээр суурилагдсан байвал тухайн цаг хугацаанд зөвхөн нэг “зогс” гэрлийг асаасан байна.

Е.3.18 Завсрын хүлээх байрлалын гэрлүүд

“Зогс” гэрэл суурилагдсанаас бусад нөхцөлд, завсрын хүлээх байрлалын гэрлүүд харагдацын нөхцөл 350м –ээс бага үед ашиглах ХБЗ-ны завсрын хүлээх байрлалд суурилагдсан байна.

Е.3.19 ХБЗ-ны хамгаалалтын /харуулын/ гэрлүүд

ХБЗ-ны хамгаалалтын /харуулын/ гэрлүүдийг ХБЗ болон явгалах замын огтлолцол бүрд доорх нөхцөлтэй бол суурилуулна. Үүнд:

- (1) ХБЗ-ны харагдацын нөхцөл 550м –ээс бага, “зогс” гэрэл байхгүй;
- (2) ХБЗ-ны харагдацын нөхцөл 550м –1200м–ийн хооронд хөдөлгөөний нягтрал их үед /цагт 25 хөдөлгөөн/

Е.3.20 Ил харааны хөтлөгч систем

Ил харааны хөтлөгч систем нь онгоцны зогсоол дахь агаарын хөлгийн нарийвчлалтай байрлалыг бусад утгаар буюу дохих үйлдлээр хийх тохиромжгүй бол ил харааны тусламж үзүүлэх шаардлагатай үед суурилагдсан байна.

Е.3.21 Замын хүлээх байрлалын гэрэл

ХБЗ-ны харагдацын нөхцөл 350м-ээс бага нөхцөлд тухайн ХБЗ-ыг ашиглах бол замын хүлээх байрлал бүрд гэрэлсуурилагдсан байна.

Е.4 Гэрэлтэй тэмдэгтүүд ба маркерууд

Е.4.1 Ерөнхий зүйл

Тэмдэгтүүд газрын хөдөлгөөний зааварчилгаа ба хяналтын системийн шаардлагын дагуу зайлшгүй зааварчлах, тодорхой байршил, эсхүл хөдөлгөөний бүсийн тодорхой байршлын талаарх мэдээллийг илэрхийлэх, бусад мэдээллээр хангахын тулд суурилагдсан байна.

Е.4.2 Гэрэлтүүлэх

Тэмдэгтүүд дараах тохиолдолд гэрэлтүүлэгдсэн байна:

- (1) ХБЗ-ны харагдацын нөхцөл 800м–ээс бага, эсхүл
- (2) тоноглолтой ХБЗ–ыг шөнөөр ашиглах бол, эсхүл
- (3) АХК 3, эсхүл 4 ба, тоноглолгүй ХБЗ –ыг шөнөөр ашиглах бол

Е.4.3 Зайлшгүй зааварчилгааны тэмдэгтүүд

(а) Зайлшгүй зааварчилгааны тэмдэгтүүд явгалж буй онгоц, эсхүл тээврийн хэрэгсэл агаарын хөдөлгөөний хяналтын цамхагийн зөвшөөрөлгүй цааш нэвтрэхийг хориглосон байршлыг заахын тулд хяналттай аэродромд суурилагдсан байна.

(b) Зайлшгүй зааварчилгааны тэмдэгтүүдэд ХБЗ-ны чиглэлийн тэмдэгт, I, II эсхүл III категориин хүлээх байрлалын тэмдэгт, ХБЗ-ны хүлээх шугамын тэмдэгт, автозамын хүлээх байрлалын тэмдэгт болон “Орохыг хориглоно” тэмдэгтүүд багтана.

(c) ХБЗ-ны хүлээх байрлал Хавсралт С.8 /a/-ийн дагуу тоноглолгүй ХБЗ, нарийвчлалгүй ойртолтын зурвас, эсхүл хөөрөх зурвасны зохих байрлалд тогтоогдсон бөгөөд ХБЗ/ ЯЗ, эсхүл ХБЗ/ХБЗ–ны огтлолцолд ХБЗ-ны чиглэлийн тэмдэгттэй хамт байна.

(d) Хавсралт С–ийн С.8(a)–ийн дагуу нарийвчлалтай ойртолтын зурвас бүхий аэродромд нэг ХБЗ-ны хүлээх байрлал тогтоогдсон бол ХБЗ-ны хүлээх шугамын тэмдэглэгээ ХБЗ-ны чиглэлийн тэмдэгттэй хамт байрлана.

(e) Хавсралт С–ийн С.8(a)–ийн дагуу нарийвчлалтай ойртолтын зурвас бүхий аэродромд хоёр, эсхүл гурван ХБЗ-ны хүлээх байрлал тогтоогдсон бол ХБЗ-тай хамгийн ойр байрших байрлал нь ХБЗ-ны чиглэлийн тэмдэгттэй хамт байрлах ба хамгийн хол байрших байрлал нь I, II, эсхүл III категориин хүлээх байрлалын тэмдэгттэй хамт байрлана.

(f) ХБЗ-ны хүлээх байрлал Хавсралт С–ийн С.8(a) –ийн дагуу ХБЗ-ны байрлалын тэмдэгттэй хамт байрлана.

(g) “Орох хориотой” тэмдэгтийг тухайн талбай, бүс рүү нэвтрэхийг хориглосон газруудад байрлуулсан байна.

Е.4.4 Мэдээлэх тэмдэгтүүд

(a) Үйл ажиллагааны шаардлагаар тэмдэгтээр тодорхойлох, байршлыг тодруулах, эсхүл маршрутын /чиглэл, эсхүл хүрэх газар/ мэдээлэл өгөх хэрэгцээтэй газарт мэдээлэх тэмдэгт байрлуулна.

(b) Мэдээлэх тэмдэгтүүдэд чиглэлийн, байршлын, хүрэх газрын, ХБЗ-аас гарах, ХБЗ чөлөөгүй, хөөрөх уулзварын /ХЗБУ –ыг заасан / тэмдэгтүүд багтана.

(c) ХБЗ-аас гарах тэмдэгтийг үйл ажиллагааны шаардлагаар ХБЗ–аас гарах хэсгийг тодорхойлох хэрэгцээтэй газарт байрлуулна.

(d) “ХБЗ чөлөөгүй” тэмдэгтийг ХБЗ-аас гарах явгалах зам тэнхлэгийн шугамын гэрэлгүй, ХБЗ-ыг чөлөөлж байгаа нисгэгчид ILS/MLS системийн аюултай/ мэдрэмтгий бүсийн периметрийг, эсхүл дотоод шилжих гадаргуугийн доод ирмэгийн ХБЗ-ны тэнхлэгийн шугамаас аль холыг нь мэдээлэхшаардлагатай газарт байрлуулна.

(e) Байршил чиглэлийн хосолсон тэмдэгтийг явгалах зам огтлолцохоос өмнө маршрутын мэдээллийг тодорхойлох зориулалтаар байрлуулсан байна.

(f) Чиглэл заах тэмдэгтийг үйл ажиллагааны шаардлагаар явгалах замуудын огтлолцол дээр, тэдгээрийн дугаар ба чиглэлийг тодорхойлох хэрэгцээтэй газруудад байрлуулна.

(g) Байршлын тэмдэгтийг ХБЗ дээр, эсхүл ХБЗ-ны огтлолцолд байрлахаас бусад тохиолдолд ХБЗ-ны дугаарлалтын тэмдэгтэй хамт байрлуулна.

(h) Байршлын тэмдэгтийг нисэхийн судалгааны дагуу шаардлагагүй гэж үзсэнээс бусад тохиолдолд чиглэл заагч тэмдэгтэй хамт байрлуулна.

Е.4.5 VOR шалгах цэгийн тэмдэгт

Аэродромд VOR шалгах цэгтэй бол түүнийг VOR шалгах цэгийн тэмдэгтээр тодруулсан байна.

Е.4.6 Замын хүлээх байрлалын тэмдэгт

Замын хүлээх байрлалын тэмдэгтийг ХБЗ руу нэвтрэх бүх замын оролт дээр байрлуулсан байна.

Е.4.7 Ил харааны тэмдэгтүүд /Маркерууд /

Маркерууд хэврэг байх шаардлагатай. ХБЗ, эсхүл ЯЗ-ын ойролцоо байрлаж байгаа тэмдэгтүүд нь жет онгоцны хөдөлгүүрийн гаднах хамгаалалтаас болон

сэнсний үзүүрээс хангалттай зайтай байхаар нам дор байрлана /гэрэл 36см–ээс ихгүй өндөртэй/

Хавсралт F — Саадыг тэмдэглэх ил харааны хэрэгслүүд

F.1 Тэмдэглэгдсэн, эсхүл гэрэлтүүлсэн байх шаардлагатай объектууд

(а) Дотоод хязгаараас 3000м-ийн зайд ойртолтын гадаргуугаас дээш гарсан, эсхүл шилжих гадаргуугаас дээш өндөртэй хөдөлгөөнгүй объектыг будган тэмдэглэгээгээр тэмдэглэх ба хэрэв шөнөөр ашигладаг аэродром бол гэрэлтүүлсэн байна. Гэхдээ -

- (1) тухайн саад нь өөр хөдөлгөөнгүй саадаар халхлагдсан бол тухайн саадыг тэмдэглэхгүй, эсхүл гэрэлтүүлэхгүй байж болно, эсхүл
- (2) тухайн саад нь өдрийн цагаар дунд зэргийн нягтралтай А маягийн гэрлээр гэрэлтүүлэгдсэн бөгөөд тэдгээрийн өндөр нь эргэн тойрны газрын түвшнээс 150м–ээс дээшгүй бол будган тэмдэглэгээ хийхгүй байж болно, эсхүл
- (3) тухайн саад нь өндөр нягтралтай гэрлээр өдрийн цагт гэрэлтүүлэгддэг бол будган тэмдэглэгээ хийхгүй байж болно, эсхүл
- (4) тухайн саад нь гэрэлт цамхаг бол нисэхийн судалгаа хийж, тухайн гэрэлт цамхагийн гэрэл хангалттай гэж үзсэн нөхцөлд гэрэлтүүлэг хийхгүй байж болно.

(b) Саадыг хязгаарлах гадаргуугаас өндөр өргөгдсөн хөдөлгөөнгүй объект нь тэмдэглэгдсэн байх ба хэрэв шөнийн нислэгт ашиглах аэродром бол гэрэлтүүлсэн байна.

(c) Зөвхөн хөдөлгөөний бүс, перрон дээр ашиглагдах агаарын хөлөг, онгоц үйлчилгээний тоног төхөөрөмж, машин техникээс бусад хөдөлгөөнтэй объект, тээврийн хэрэгслийг саадад тооцсон нөхцөлд тэмдэглэгээ хийгдэх ба хэрэв тээврийн хэрэгсэл ба аэродромыг шөнийн нислэгт, эсхүл хараа бага нөхцөлд ашигладаг бол гэрэлтүүлсэн байна.

(d) Хөдөлгөөний бүс дэх нисэхийн зориулалт бүхий өргөгдсөн гэрлүүд нь өдрийн цагт анзаарагдахаар тэмдэглэгдсэн байна. Хөдөлгөөний бүсэд өргөгдсөн гэрэл дээр, эсхүл гэрэлтэй тэмдэгт дээр саадын гэрэл суурилуулахыг хориглоно.

(e) Явгалах замын тэнхлэг, перроны явгалах зам, эсхүл онгоцны зогсоолын явгалах шугамнаас Хүснэгт F-1 –д заасан зай хэмжээний дотор орших бүх саадууд тэмдэглэгдсэн байх ба шөнийн нислэгт ашиглах аэродромын хувьд гэрэлтүүлэгдсэн байна.

Хүснэгт Ф -1. Саадын тэмдэглэгээ ба гэрэлтүүлгийн шаардлагууд

Аэродромын хяналтын үсгэн код	Онгоцны зогсоолын явгалах шугамаас бусад явгалах замын тэнхлэгээс объект хүртэлх зай (метрээр)	Онгоцны зогсоолын явгалах шугамын тэнхлэгээс объект хүртэлх зай (метрээр)
A	16.25	12
B	21.5	16.5
C	26	24.5
D	40.5	36
E	47.5	42.5
F	57.5	50.5

F.2 Объектийн тэмдэглэгээ

(a) Тухайн объектыг өөрөөр тэмдэглэх шаардлагагүй, хэлбэр дүрс, хэмжээ, эсхүл өнгө нь хангалттай тод харагдахуйц байхаас бусад нөхцөлд аль тохиромжтой байдлаар, хэрэв будгаар тэмдэглэхэд тохиромжгүй бол тэмдэгтүүд, эсхүл туг дарцгийг тэдгээр объектын дээр, эсхүл дор байрлуулах буюу тэмдэглэгээ хийгдсэн байх шаардлагатай суурилагдсан бүх объектууд өнгөөр будагдсан байх шаардлагатай.

(b) Тэмдэглэгээ хийгдсэн байх шаардлагатай бүх хөдөлгөөнт объектууд өнгөөр будагдсан байх, эсхүл туг дарцагаар тэмдэглэгдсэн байх шаардлагатай.

F.3 Тэмдэгтүүд хэрэглэх

Тухайн объект руу онгоц ойртож байна гэж үзвэл агаар сайхан нөхцөлд бүх чиглэл рүү агаараас харагдах объектын хувьд 1000м зайнаас, газраас харагдах объектод 300м зайнаас танигдаж байхаар, ерөнхий тайлбарыг хадгалан тухайн объектын дээр, эсхүл ойролцоо хажууд нь байрлах тэмдэгтүүд хараа татахаар байрлалд байрлах шаардлагатай.Тэмдэгтүүдийн дүрс, загвар өөр мэдээлэл өгөх зорилгоор суурилагдсан бусад тэмдэгт, самбараас ялгарахуйц байх шаардлагатай ба объектоос учирч болох аюул тэмдэглэгдсэнээр нэмэгдэхгүйбайхаар суурилагдсан байна.

F.4 Туг дарцаг хэрэглэх

(a) Объектыг тэмдэглэх туг дарцаг объектын орой дээр, эргэн тойрон, эсхүл дээд ирмэгийг тойрон байрлана.Хэрэв туг дарцаг нь том байгууламж, эсхүл ойрхон зайтай бүлэг объектыг тэмдэглэх бол хамгийн багадаа 15м тутамд байрлана. Туг дарцагаар тэмдэглэх ньобъектоос учрах аюулыгнэмэгдүүлэхгүйгээр суурилагдсан байна.

(b) Хөдөлгөөнгүй объектыг тэмдэглэх туг дарцаг нь 0.6м^2 -аас багагүй, хөдөлгөөнтэй объектыг тэмдэглэх бол 0.9 м^2 -аас багагүй талбайтай байна.

(с) Хөдөлгөөнтэй объектыг тэмдэглэх дарцаг нь дөрвөлжин нүдтэй байх ба нүд тус бүрийн талын хэмжээ нь 0.3м–ээс багагүй байна. Нүднүүдийн өнгө нь ялгаатай байх ба цаад харагдах дэвсгэр өнгөнөөс ялгарахаар байна. Хэрэв цаад дэвсгэр өнгөнөөс өөр байвал улбар шар, цагаан, эсхүл улаан цагаан өнгө тохиромжтой.

F.5 Объектыг гэрэлтүүлэх

(а) Хавсралт F.1 –д заасан гэрэлтүүлэх шаардлага бүхий объектуудыг бага, дунд, эсхүл өндөр чадлын саадын гэрлээр, эсхүл тэдгээр гэрлүүдийг хослуулан гэрэлтүүлсэн байна.

(б) С маягийн бага чадлын саадын гэрлүүд онгоцыг оролцуулахгүй тээврийн хэрэгслүүд дээр болон бусад хөдөлгөөнт объектууд дээр гэрэлтсэн байна.

(с) Д маягийн бага чадлын саадын гэрлүүд Фоллоу Ми */Намайг дага/* машин дээр гэрэлтсэн байна.

Хавсралт G — Ашиглахыг хориглосон талбайг тэмдэглэх ил харааны хэрэгслүүд

G.1 Хаалттай зурвас, явгалах замууд

Бүх онгоц ашиглахад бүрмөсөн хаагдсан ХБЗ, эсхүл явгалах замууд, эсхүл тэдгээрийн хэсэг дээр хаалттай тэмдэглэгээ харагдаж байх шаардлагатай.

G.2 Ачаалал даахгүй гадаргуунууд

Явгалах зам, хүлээх байрлалууд, перроны хөвөөнүүд болон бусад ачаалал даахгүй гадаргуунууд ачаалал даах гадаргуугаас ялгарч харагдахгүй байснаас хэрэв агаарын хөлөг ашигласнаас үүдэн түүнд гэмтэл учруулж болохуйц байдал үүсэхээр байвал тэдгээр гадаргуу болон ачаалал даах гадаргуугийн хооронд хязгаар байх шаардлагатай ба ачаа даах гадаргууг хажуугийн зураасан тэмдэглэгээгээр будаж тэмдэглэсэн байна.

G.3 Ашиглалтгүй талбайнууд

Агаарын хөлөг дээгүүр нь аюулгүй өнгөрөн гарах боломжтой ч, агаарын хөлгийн хөдөлгөөн үйлдэхэд тохиромжгүй хүлээх талбай, эсхүл явгалах зам, перроны аливаа хэсэг ашиглалтгүй тэмдэгт, наалт хийгдсэн, харагдаж байх ёстой. Шөнөөр ашиглах хөдөлгөөний бүсэд ашиглалтгүй талбайн гэрэл хэрэглэх шаардлагатай.

Хавсралт Н — Цахилгаан хангамжийн системүүд

Н.1 Аэронавигацийн байгууламжийн цахилгаан хангамжийн системүүд

(a) Аэронавигацийн байгууламжийн ажиллагааг аюулгүй явуулахад хангалттай анхан шатны цахилгаан хангамжаар хангагдсан байна.

(b) 139.5(аа)(1)–д заасан аэродромуудын хувьд ил харааны болон радио навигацийн тоног төхөөрөмжийн цахилгаан хангамжийн системийн дизайн, хангалт нь тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтэл гарахад нисгэгчид буруу мэдээлэл өгөх, **эсхүл хангалтгүй ил харааны болон ил харааны бус зааварчилгаа өгөх боломжгүй хийгдсэн байх ёстой.**

Н.2 Ил харааны тоноглол

(a) Нарийвчлалтай ойртолтын ХБЗ–ны хувьд хүснэгтэд тогтоосон нарийвчлалтай ойртолтын зурвасны тохиромжтой зэрэглэлийн шаардлагыг хангах цахилгаан хангамжийн хоёрдогч эх үүсвэртэй байна. Хоёрдогч эх үүсвэр шаардагдах байгууламжид цахилгаан хангамжийн холболт нь эхний эх үүсвэр доголдоход хоёрдогч эх үүсвэрт автоматаар холбогдож байхаар зохион байгуулагдсан байна.

(b) Зурвасны харагдах түвшин нөхцөл 800 м –ээс бага, хөөрөлт үйлдэх ХБЗ–ны хувьд хүснэгт Н-1 –д заасан холбогдох шаардлагыг хангах хоёрдогч цахилгааны эх үүсвэртэй байхыг шаардана.

Н.3 Системийн төлөвлөлт

(a) Зурвасны харагдах түвшин нөхцөл 550м –ээс бага ХБЗ–ны хувьд Хүснэгт Н-1 –д үзүүлсэн цахилгаан хангамжийн системүүд, гэрлүүд, гэрлүүдийн системийн хяналтын тоног төхөөрөмжийн гэмтэл гарахад нисгэгчийг ил харааны зааварчилгаагаар, эсхүл буруу мэдээллээр хангахгүй байхаар төлөвлөгдөж, хийгдсэн байна.

(b) Аэродромын цахилгаан хангамжийн хоёрдогч эх үүсвэр нь нөөц нэмэлт шугам ашиглаж буй үед бие даасан болон байнгын бэлэн байдлын хангаж байгааг бататгахын тулд тэдгээр хангалтууд нь бодит биетээр болон тусдаа цахилгааны эх үүсвэр шугамтай байна.

(c) Хэрэв ХБЗ–ны гэрлээр ба явгалах замын гэрлээр тоноглогдсон ХБЗ нь стандарт явгалах маршрутын хэсэг байгаа нөхцөлд тэдгээр гэрлийн системүүд нь хоёр төрлийн гэрэл зэрэг ажиллах боломжийг хязгаарлахын тулд угсарч холбогдсон, нэгдсэн байна.

Н.4 Хяналт хийх

Гэрлийн систем агаарын хөлгийг хянах зорилгоор ашиглаж байгаа нөхцөлд эдгээр системүүд нь хяналтын үүрэг гүйцэтгэхэд нөлөөлж болох аливаа гэмтлийн шинж тэмдгийг мэдрэхийн тулд автомат хяналттай байна. Энэ мэдээлэл НХҮН–д автоматаар дамжуулагдах ёстой.

Хүснэгт Н-1. Цахилгааны хоёр дахь эх үүсвэрт тавигдах шаардлагууд

ХБЗ-ны төрөл	Цахилгаан тэжээл шаардах гэрэл, тоноглолууд	Сэлгэн залгалт хийх дээд хугацаа	Тайлбар
Нарийвчлалтай ойртолтын CAT I	Ойртолтын гэрлийн систем	15 секунд	
	ХБЗ-ны хажуу	15 секунд	c
	Ил харааны ойртолтын налуу заагч	15 секунд	a,c
	ХБЗ-ны босго	15 секунд	c
	ХБЗ-ны төгсгөл	15 секунд	
	Үндсэн явгалах зам	15 секунд	a
Саад	15 секунд	a	
Нарийвчлалтай ойртолтын CAT II/III	Ойртолтын гэрлийн системийн дотоод 300 м хэсэг	1 секунд	
	Ойртолтын гэрлийн системийн бусад хэсэг	15 секунд	
	Саад	15 секунд	
	ХБЗ-ны хажуу	15 секунд	a
	ХБЗ-ны босго	1 секунд	
	ХБЗ-ны төгсгөл	1 секунд	
	ХБЗ-ны тэнхлэг шугам	1 секунд	
	ХБЗ-ны суултын бүс	1 секунд	
	Зогс шугамын бүх гэрлүүд	1 секунд	
Үндсэн явгалах зам	15 секунд		
Зурвасыг харах төвшин 550 м – ээс бага үеийн хөөрөлт үйлдэх зурвас	ХБЗ-ны хажуу	15 секунд	b
	ХБЗ-ны төгсгөл	1 секунд	
	ХБЗ-ны тэнхлэг шугам	1 секунд	
	Зогс шугамын бүх гэрлүүд	1 секунд	a
	Үндсэн явгалах зам	15 секунд	a
	Саад	15 секунд	

Тайлбар:

- нислэгийн аюулгүй ажиллагаанд зайлшгүй чухал учраас хоёр дахь эх үүсвэртэй холбогдсон.
- ХБЗ-ны тэнхлэгийн шугамын гэрэлгүй үед нэг секунд
- Ойртолтын нөхцөл нь аюултай ба уулархаг нутаг дэвсгэр дээгүүр өнгөрдөг бол нэг секунд.